

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛСЫН ТӨСВИЙН 2021 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ОРОН НУТГИЙН САНАЛД
ҮНДЭСЛЭЭГҮЙ, ТӨЛӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ
БАТАЛЖ, ЭРХ ШИЛЖҮҮЛСЭН БАЙНА.

АУДИТЫН КОД: ХӨА-2022/16-21-ШТА-ГА

Хөвсгөл аймаг
2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх
аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Э.Бат-Эрдэнэ

Утас: 88090438 Цахим хаяг: Baterdenee@audit.gov.mn

Аудитор: З.Даваадорж

Утас: 89100230 Цахим хаяг: Davaadorjz@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.
https://audit.mn/?page_id=579

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

Хөвсгөл аймаг дахь
Төрийн аудитын газар

Тэргүүлэх аудитор

А.Эрдэнэбаатар

Аудитын менежер

Б.Тэгшдэлгэр

Ахлах аудитор

Э.Бат-Эрдэнэ

Аудитор

З.Даваадорж

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл гарвал
70384043 дугаарын утас,
70383793 дугаарын
факсаар харилцана уу.

ХАЯГ: Мөрөн сум Аймгийн
ЗДТГ-ын “А” корпус 3
давхар

Цахим хаяг:

audit.mn/?page_id=579

2022 оны 04 дүгээр сар

Товчилсон үгийн жагсаалт

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй
Ерөнхий мэдээлэл

**Бүлэг 1. Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл,
арга хэмжээг баталж, эрх шилжүүлсэн байна.**

А.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг аймгийн ТЭЗ-ийн саналд үндэслээгүй байна..

А.2 Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын зураг төсөлд магадлал хийх ажлыг зохион байгуулах чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.

А.3 Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.

**Бүлэг 2. Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний
хэрэгжилт 78 хувийн гүйцэтгэлтэй байна.**

Б.1 Зураг төсвийн зөвлөх үйлчилгээ хийлгэх, үнэлгээний хороо байгуулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах ажиллагаанд хугацаа алдсанаас төсөл, арга хэмжээний хэрэгжилт удааширсан байна.

Б.2 Захиалагч нь гүйцэтгэгч байгууллагын гэрээний хугацаа дууссан байхад гэрээнд өөрчлөлт оруулаагүй, алданги тооцоогүй, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын гэрээг үнэлж, дүгнээгүй байна.

Б.3 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг бодитой хянаагүйгээс хийгдээгүй ажлын гүйцэтгэлд санхүүжилт олгосон байна.

Б.4 Гүйцэтгэгч ажлаа хугацаанд нь гүйцэтгээгүйгээс батлагдсан санхүүжилтийг бүрэн ашиглахын тулд тухайн жилийн санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

Б.5 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцохгүй байна.

Дүгнэлт

Зөвлөмж

Зөрчлийн жагсаалт

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХӨА	Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар
ШТА	Шууд тайлагнах аудит
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТАХ	Төсөл арга хэмжээ
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
ХНХЯ	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам
БХБЯ	Барилга хот байгуулалтын яам
ХАА	Худалдан авах ажиллагаа



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ**

2022 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/07.

Мөрөн сум

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйлийн 9.1, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 “Эрх үүрэг шилжүүлэх тухай” дугаар тушаалын тавдугаар хавсралтын 2.4 дэх заалт, 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 3.2 дахь, 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Аудитын гуравдугаар газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Орон нутгийн өмчийн газар, Барилга захиалагчийн хяналтын төв ОНӨААТҮГ-д тус тус хүргүүлэхийг ахлах аудитор /Э.Бат-Эрдэнэ/-т даалгасугай.

3. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж үр дүнг 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (Г.Мөнгөнхуяг), аймгийн Засаг дарга (Ш.Идэрбаясгалан), аймгийн Засаг даргын Тамгын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Ариунбат), Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Должинсоргодог), аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Б.Оюунтуяа), Газрын харилцаа, барилга байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг) нарт зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер (Б.Тэгшдэлгэр), ахлах аудитор (Э.Бат-Эрдэнэ) нарт даалгасугай.

5. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон хүлээлгэн өгөхийг аудитыг баг /З.Даваадорж/-т үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

Дарга, Тэргүүлэх аудиторын 2022 оны
05 дугаар сарын 02-ны өдрийн А/07
дугаартай тушаалын хавсралт

Аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт

№	Акт, албан шаардлагын утга	Хариуцах байгууллага	Акт, албан шаардлагын дугаар
1	Сахилгын хариуцлага тооцуулах тухай	Аймгийн Засаг дарга	50/A2250433/ХӨА-2022/16-21-ШТА-ГА
2	Сахилгын хариуцлага тооцуулах тухай	Аймгийн Засаг дарга	53/A2250433/ХӨА-2022/16-21-ШТА- ГА
3	Сахилгын хариуцлага тооцуулах тухай	Аймгийн Засаг дарга	49/A2250433/ХӨА-2022/16-21-ШТА- ГА
4	Сахилгын хариуцлага тооцуулах тухай	Аймгийн Засаг дарга	47/A2250433/ХӨА-2022/16-21-ШТА- ГА
5	Зөрчил арилгах тухай	ОНӨГ	48/A2250433/ХӨА-2022/16-21-ШТА- ГА
6	Зөрчил арилгах тухай	ОНӨГ	52/A2250433/ХӨА-2022/16-21-ШТА- ГА
7	Зөрчил арилгах тухай	Барилга захиалагчийн хяналтын төв	51/A2250433/ХӨА-2022/16-21-ШТА- ГА
8	Төлбөрийн акт барагдуулах тухай	ХБТХОХ	11//A2250433/ХӨА-2022/16-21-ШТА- ГА

оо0оо

Дүгнэлт гаргах ажлын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл:

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Аудитын сэдэв батлах тухай” 6 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2022 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаалаар баталсан Үндэсний аудитын газраас гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д гүйцэтгэлийн аудитыг хийлээ.

Аудитын зорилт:

“Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд” Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан нэгдсэн төлөвлөгөө, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын баталсан дэд төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан, дүнг Үндэсний аудитын газар болон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- ❖ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх тогтолцоо үр нөлөөтэй байгаа эсэх;
- ❖ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, улсын төсвөөс олгосон санхүүжилтийн зарцуулалт үр дүнтэй байгаа эсэх;
- ❖ Орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт үр дүнтэй хийгдсэн эсэх.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитаар 2021 онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээ хэрэгжүүлсэн Төсвийн ерөнхийлөн захирагч түүний харьяа Засаг даргын Тамгын газар, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Барилга захиалагчийн хяналтын төв болон бусад холбогдох төрийн байгууллага, төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллагын холбогдох үйл ажиллагааг хамруулав.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 300, 3000-3100, 5400-5499, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудитын Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудитын Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим” MNS 6817-7:2020 “Төрийн аудит Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим МУ-ын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал” зэргийг баримтлан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлсийг цуглуулах, нягтлан шалгах, ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, баримтад дурдсан мэдээлэлд шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийж, үр дүнг тооцох арга зүйг ашиглав

Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах, хяналт тавихтай холбоотой хууль, эрх зүйн актыг судлах, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, мэдээлэл, тодруулга авах, асуудал эрхэлсэн байгууллага болон холбоотой талуудаас гаргуулсан баримт, мэдээлэл, судалгаа, тайланг судалж, дүнг нэгтгэн аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, тэдгээрийн дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын багийн бүрэлдэхүүн хугацаа:

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хянан удирдаж, аудитын менежер Б.Тэгшдэлгэр аудитын үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Э.Бат-Эрдэнэ, аудитор О.Ганболд, З.Даваадорж нар аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитыг гүйцэтгэхэд тулгарсан хүчин зүйлс: Орон нутаг дахь Төрийн аудитын газар нь төрөлжсөн хэлбэрээр аудитыг гүйцэтгэх боломжгүй байдаг тул аудитын хугацаанд санхүүгийн тайлангийн аудитууд давхцан гүйцэтгэлийн аудитыг гүйцэтгэхэд цаг хугацааны хувьд хязгаарлагдмал байлаа.


Ерөнхий мэдээлэл: Улсын Их Хурлаар 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Монгол улсын 2021 оны Төсвийн тухай хууль батлагдаж түүнд Хөвсгөл аймагт 2021 онд 116,369.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 74 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсанаас 17,131.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Үүнээс 34,802.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2021 онд 15,410.0 сая төгрөгөөр санхүүжигдэх 44 төсөл арга хэмжээг Засгийн газрын тогтоол болон Төсвийн ерөнхийлөн захирагчдын шийдвэрээр эрх шилжүүлэхээр шийдвэрлэсэн боловч 2,315.0 сая төгрөгийн Гэр хорооллын усан хангамжийг сайжруулах шугам, цэвэр усны эх үүсвэр, Сумын төвийн бетон авто зам, 8.7 км /Хөвсгөл, Тариалан сум/, Жаргалант-Галтын авто замын засвар /Хөвсгөл, Жаргалант, Галт сум/ гэсэн 3 төсөл, арга хэмжээний эрх шилжиж ирээгүй байна.

Дээрх 3 төсөл, арга хэмжээг хасаж тооцвол Хөвсгөл аймагт 22,193.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2021 онд 13,095.0 сая төгрөгөөр санхүүжигдэх 41 төсөл, арга хэмжээ эрх шилжиж ирсэн байна. Төсөл, арга хэмжээний санхүүжилтэд 2021 онд 12,302.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Тайлант онд зарим төсөл, арга хэмжээг 65 төсөл, арга хэмжээнд багц болгон хуваасан байна. Төлөвлөсөн төсөл, арга хэмжээнээс 6,932.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 45 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 249.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй, 6,167.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 14 төсөл арга хэмжээний хэрэгжилт дутуу дараа онд шилжсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсвийн 50-ас дээш хувийг барилга байгууламж, тоног төхөөрөмж эзэлж байна. Төсөл арга хэмжээг нэр төрөл тус бүрээр графикаар харуулбал:



БҮЛЭГ А:

ТӨЛӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ БАТАЛЖ, ЭРХ ШИЛЖҮҮЛСЭН БАЙНА.

A.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг аймгийн ТЕЗ-ийн саналд үндэслээгүй байна.

Эрх шилжсэн төсөл арга хэмжээний ихэнх нь бодлогын баримт бичигт ерөнхий нэршлээр батлагдсан байна.

Хөвсгөл аймгийн Засаг даргад эрх шилжин хэрэгжсэн хөрөнгийн оруулалтын жагсаалтад батлагдсан 41 төсөл арга хэмжээний 15 нь өмнөх оноос шилжих, 26 нь 2021 онд хэрэгжиж эхлэх, үүнээс 10 нь дараа онд үргэлжлэн хэрэгжих хөрөнгө оруулалт байна.

Шинээр хэрэгжсэн 26 төсөл, арга хэмжээнээс улсын төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн хөтөлбөрт тусгагдаагүй 5 төсөл, арга хэмжээ батлагдсан байна. Бусад төсөл, арга хэмжээ нь бодлогын баримт бичигт нийцэж байгаа боловч ихэвчлэн ерөнхий байдлаар тусгагдсан байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан байдлыг харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №1

№	Нэр	Тусгагдсан тоо	Үүнээс	
			Шууд туссан ТАХ-ний тоо	Ерөнхий байдлаар туссан ТАХ-ний тоо
1	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн хөтөлбөр	20	-	20
2	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	26	4	22
3	Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	26	4	22

Улсын их хурлаас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээг төлөвлөж, батлахдаа бодлогын баримт бичгүүдэд тодорхой ерөнхий нэршлээр бус тодорхой заагдсан төсөл, арга хэмжээг баталбал бодлогын баримт бичигт заагдсан хүрэх үр дүнд илүү нөлөөтэй байхаар байна.

Хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээнүүд нь аймгийн ТЕЗ-ийн саналд үндэслэгдээгүй байна.

Хөвсгөл аймгийн Засаг дарга нь Сангийн сайдын 2018 оны 295 тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам”-ын 3.4-т заасны дагуу 2020 оны А/240 дүгээр захирамжаар “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлж, эрэмбэлэх ажлын хэсэг”-ийг байгуулсан байна. Ажлын хэсэг болон Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс нь журмын 3.2-3.9-д заасны дагуу сумдын Засаг дарга нар болон хэлтэс, агентлаг, газрын дарга нараас хөрөнгө оруулалтын саналыг авч, эрэмбэлж, ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцүүлэн, аймгийн Засаг даргын улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг боловсруулж холбогдох 8 яаманд 57,666.4 сая төгрөгийн 27 төсөл, арга хэмжээг цахим систем болон албан тоотоор хүргүүлсэн байна. /Санал хүргүүлсэн тоо, төсөвт өртгийг хүснэгт №2-оор харуулав./

Хүснэгт №2

№	Санал хүргүүлсэн яам	ТАХ-ний тоо			Төсөвт өртөг	2021 онд санхүүжих
		Нийт	Он дамжих	Шинэ		
1	ЗГХЭГ	3		3	3,854.0	2,654.0
2	БХБЯ	8		8	2,302.3	2,302.3
3	БШУЯ	7		7	37,656.0	14,500.0
4	ЗТХЯ	1		1	5,218.0	2,000.0
5	ЭХЯ	2		2	3,394.2	1,554.2
6	БОАЖЯ	2		2	2,015.0	1,015.0
7	ХЗДХЯ	1		1	140.9	140.9
8	ЭМЯ	3		3	3,087.0	2,355.0
	Дүн	27	0	27	57,666.4	26,521.4

Аймгийн Засаг даргын улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний санал хүргүүлсэн 27 төсөл, арга хэмжээнээс 26 төсөл, арга хэмжээг 2021 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтад батлаагүй байгаа нь улсын төсвийн хөрөнгө оруулалтыг аймгийн Засаг даргын саналд үндэслээгүй болохыг харуулж байна.

Сангийн яам нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээг орон нутгийн, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад үндэслээгүй, эрэмбэлээгүй байна.

Сангийн сайдын 2018 оны 295 тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам”-ын 3 дахь хэсэгт зааснаар аймгийн Засаг дарга холбогдох яамдад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний санал хүргүүлэх яамд нь саналыг хүлээн авч нэгтгэн үнэлж, эрэмбэлэн Сангийн яаманд хүргүүлэх, Сангийн яам нь яамдаас ирсэн саналыг хүлээн авч нэгтгэн эрэмбэлж, ач холбогдолтой төслийг тодорхойлж, дүгнэлт гарган төсвийн төсөлд тусган УИХ-аар хэлэлцүүлэх гэсэн дарааллаар улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт хийгдэж байна. Үүнийг хяналттай боловсронгуй болгох үүднээс хөрөнгө оруулалтын цахим удирдлагын систем нэвтрүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналд туссан хөрөнгө оруулалтыг 2021 оны Төсвийн тухай хуульд батлаагүй байгаагаас үзэхэд журмаар тогтоосон хөрөнгө оруулалтыг төлөвлөх тогтолцоо хэрэгжээгүй, яамд болон орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид нь 2 өөр замаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээгээ төлөвлөсөн байдал харагдаж байна. Иймд аймгийн Засаг даргын улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналаар хүргүүлсэн хөрөнгө оруулалт нь 2021 оны Төсвийн тухай хуульд тусгагдаагүй байдлаас харахад Сангийн яам орон нутгийн хэрэгцээ шаардлагыг үндэслээгүй, эрэмбэлээгүйг харуулж байна.

A.2 Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын зураг төсөлд магадлал хийх ажлыг зохион байгуулах чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.

Зарим төсөл арга хэмжээний зургийн ажлын даалгаврыг инженер геологийн дүгнэлт, техникийн нөхцөлүүд, газрын зөвшөөрөлд үндэслэн боловсруулаагүй байна.

Шинээр эрх шилжин хэрэгжсэн 26 төсөл, арга хэмжээний 7 төсөл арга хэмжээ нь 31 багц болон задарч нийт 50 ажил болсон бөгөөд үүнээс 28 нь барилга, байгууламж буюу зураг, төсөв шаардлагатай төсөл арга хэмжээ байна. Зураг, төсөв шаардлагатай 28 төсөл, арга хэмжээнээс 4 төсөл, арга хэмжээг түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр ажлын даалгаврыг боловсруулсан байна. Зураг төсвийн ажлын даалгавар боловсруулахдаа дараах төсөл арга хэмжээнүүдийн ажлын даалгаврыг инженер геологийн дүгнэлт, техникийн нөхцөлүүд, газрын зөвшөөрөлд үндэслэн боловсруулаагүй байна. Үүнд:

1. Зураг төсөл боловсруулах ажлын даалгаваргүй 2 ТАХ байна.
 - ❖ Сургуулийн дотуур байрны гүний худгийн шугам сүлжээний засвар /Хөвсгөл, Чандмань-Өндөр сум/
 - ❖ Цэцэрлэгийн сантехникийн засвар /Хөвсгөл, Алаг-Эрдэнэ сум/
2. Инженер геологийн дүгнэлтгүй дараах 10 ТАХ байна. Үүнд:

Хүснэгт №3

№	ТЕЗ	Төсөл арга хэмжээний нэр
1	ЗГХЭГ	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр-багц-3: Бэлчээрийн худаг /Улаан-Уул сум Мунгараг баг Байцын ар/
2		Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр-багц-4: Багийн төвийн барилга барих /Тариалан сум, Таван толгой баг/
3	БОАЖЯ	"Соёмбо" цэцэрлэгт хүрээлэн /Хөвсгөл, Мөрөн сум/
4	ХНХЯ	Ахмадын өргөөний барилга /Хөвсгөл, Шинэ-Идэр сум/
5	БХБЯ	Ундны усны худаг /Хөвсгөл, Мөрөн сум/
6		Халуун усны барилга /Хөвсгөл, Тариалан сум/
7	ХХААХҮЯ	Бэлчээрийн худаг /Хөвсгөл, Тариалан, Тосонцэнгэл, Цэцэрлэг сум/-багц 1- Тариалан суманд бэлчээрийн худаг гаргах
8		Бэлчээрийн худаг /Хөвсгөл, Тариалан, Тосонцэнгэл, Цэцэрлэг сум/-багц 2- Тосонцэнгэл суманд бэлчээрийн худаг гаргах

9		Бэлчээрийн худаг /Хөвсгөл, Тариалан, Тосонцэнгэл, Цэцэрлэг сум/-багц 3- Цэцэрлэг суманд бэлчээрийн худаг гаргах
10		"Шинэ хөдөө" төсөл /Хөвсгөл/ -Багц-6 - Инженерийн хийцтэй гүний өрмийн худаг

3. Техникийн нөхцөл бүрэн бус дараах 4 ТАХ байна. Үүнд:

Хүснэгт №4

№	ТЕЗ	ТАХ нэр	Дутуу техникийн нөхцөл
1	ЗГХЭГ	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр-багц-4: Багийн төвийн барилга барих /Тариалан сум, Таван толгой баг/	Цахилгаан хангамж
2	БОАЖЯ	"Соёмбо" цэцэрлэгт хүрээлэн /Хөвсгөл, Мөрөн сум/	Цахилгаан хангамж, дулаан хангамж, ус хангамж, ариутгах татуурга, холбоо дохиолол
3	ХНХЯ	Ахмадын өргөөний барилга /Хөвсгөл, Шинэ-Идэр сум/	Цахилгаан хангамж, дулаан хангамж
4	БХБЯ	Халуун усны барилга /Хөвсгөл, Тариалан сум/	Цахилгаан хангамж, дулаан хангамж

4. Газрын зөвшөөрөлгүй дараах ТАХ байна. Үүнд:

Хүснэгт №5

№	ТЕЗ	ТАХ нэр
1	БОАЖЯ	"Соёмбо" цэцэрлэгт хүрээлэн /Хөвсгөл, Мөрөн сум/
2	БХБЯ	Ундны усны худаг /Хөвсгөл, Мөрөн сум/
3	ХХААХҮЯ	"Шинэ хөдөө" төсөл /Хөвсгөл/ - Багц-5 - Үхрийн байр барих

5. Дараах 6 төсөл арга хэмжээний газрын зөвшөөрөл, техникийн нөхцөлийг зургийн ажлын даалгавар боловсруулсны дараа олгосон байна:

Хүснэгт №6

№	ТЕЗ	ТАХ нэр	Зургийн даалгавар боловсруулсан огноо	Газрын зөвшөөрөл олгосон огноо	Техникийн нөхцөл олгосон огноо
1	ХНХЯ	Баянзүрх сумын Ахмадын өргөөний барилга	2021.01.15	2021.11.10	2021.05.06
2	ХНХЯ	Цагаан-Үүр сумын Ахмадын өргөөний барилга	2021.01.16	2009.08.06	2021.04.23
3	ХНХЯ	Чандмань-Өндөр сумын Ахмадын өргөөний барилга	2021.01.15	2011.03.30	2021.04.23
4	ЗГХЭГ	Багийн төвийн барилга барих /Тариалан сум, Таван толгой баг/	2021.05.03	2021.12.09	-
5	БХБЯ	Алаг-Эрдэнэ сумын халуун усны барилга	2021.01.15	2021.02.02	2021.04.23
6		Баянзүрх сумын халуун усны барилга	2021.01.15	2021.01.15	2021.04.23

Дээрх барилгын ажлуудын зураг, төсөл боловсруулах ажлын даалгаврыг газрын зөвшөөрөлгүй, инженер геологийн дүгнэлтгүй, техникийн нөхцөлгүй боловсруулж баталсан байгаа нь Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-д “эрх бүхий байгууллагаас олгосон газрын зөвшөөрөл, зургийн даалгавар, норм, нормативын баримт бичиг, стандарт, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, техникийн нөхцөл, инженер хайгуулын судалгаанд үндэслэн боловсруулагдсан байх” заасан барилгын зургийн шаардлага хангахгүй байна.

Барилга байгууламжийн зураг төслийг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй хуулийн этгээд боловсруулж, баталгаажуулсан байна.

Зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээг "ЭмЭнЭсЖи"ХХК, "Бабб" ХХК, "Итгэлт чандмань"ХХК, "Онч тэнхлэг" ХХК, "Престиж инженеринг" ХХК, "Гранд лайн прожект" ХХК, "Адмо наяд" ХХК, "Бодит чадал"ХХК гэсэн 8 зөвлөх үйлчилгээний компани гүйцэтгэсэн бөгөөд эдгээр компаниуд нь тухайн чиглэлдээ зөвлөх мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдүүд байна.

Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулахад олгосон зардлыг бодит гүйцэтгэл болон зургийн жишиг үнийг үндэслэсэн олгосон байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/156 дугаар захирамжаар зөвлөх үйлчилгээ авах төсөвт өртгийн дээд хязгаарыг төсөл арга хэмжээ тус бүрээр тогтоосон байна. Засаг даргын тогтоосон зураг төслийн үнэ нь Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 108 дугаар тушаалаар батлагдсан “Зураг төслийн ажлын жишиг үнэ” дүрэмд нийцсэн байна.

Түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөс бусад 24 төсөл, арга хэмжээнд зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулж 11 төсөл арга хэмжээний 28.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Зураг төслийн ажлыг 100 хувь гүйцэтгүүлж хүлээн авсан байна.

Шинээр баригдах барилга байгууламжийн зураг төсвийн 70 хувийг магадлалаар баталгаажуулаагүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шинээр эрх шилжин хэрэгжсэн 28 барилга, байгууламжийн ажлын зураг, төслөөс 8 зураг, төсөлд Барилга хөгжлийн төвөөс магадлал хийгдсэн бол үлдсэн 20 барилга, байгууламжийн ажлын зураг төслийг аймгийн Ерөнхий архитектор баталгаажуулж ажилласан байна. Энэ нь Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.5¹ дахь заалттай нийцэхгүй байна. Зургаар харуулав. Зураг-1

Батлав: ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР

Хөвсгөл аймаг Тариалан сум

НИЙТИЙН ХАЛУУН УСНЫ БАРИЛГА

(Ажлын зураг)

ЗӨВШӨӨРСӨН:

Албан тушаал	Нэр	Гарын үсэг
Хөвсгөл аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын хэлтсийн дарга	Б.Энхжаргал	
Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газрын хангаар: хамгаалах хэлтсийн улсын анхан шатны хэлтэс	Л.Бямбасүрэн	

БОЛОВСРУУЛСАН:

Албан тушаал	Нэр	Гарын үсэг
“Итгэлт Чандмань” ХХК-ийн захирал	Н.Ууганцэцэг	
Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газрын хангаар: хамгаалах хэлтсийн улсын анхан шатны хэлтэс	Х.Эгиймаа	

Батламсэрээжид

Хөвсгөл аймаг 2021 он

Зөрчил гарах үндсэн шалтгаан нь орон нутагт байгаа Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 6.1.-д заасан зураг төсөлд магадлал хийх ажлыг зохион байгуулах чиг үүрэг болон Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4²-т заасан хяналтыг хангалтгүй хэрэгжүүлж байгаагаас шалтгаалсан байна.

¹ 25.2 Магадлалыг дараахь зураг төсөлд хийнэ: 25.2.5.энэ хуулийн 10.1.2, 10.1.3-т заасан ангилалд хамаарах улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр барих барилга, байгууламжийн төсөв, нэгдсэн төсөв.

² Энэ хуулийн 25.2, 25.3-т заасан зураг төсөлд магадлал хийлгээгүй бол барилгын ажлын зөвшөөрөл олгохыг хориглоно.

А.3 Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.


Шинээр эрх шилжин хэрэгжсэн төсөл арга хэмжээнээс орон нутагт хэрэгцээ шаардлагагүй дараах төсөл, арга хэмжээ батлагдсан байна. Үүнд:

Ахмадын өргөөний барилга /Хөвсгөл, Шинэ-Идэр сум/ төсөл, арга хэмжээ нь Шинэ-Идэр суманд баригдаж байгаа 2 дахь ахмадын өргөө бөгөөд өмнө нь орон нутгийн төсвөөр ахмадын өргөө баригдсан тул энэ хөрөнгө оруулалт орон нутагт хэрэгцээ шаардлагагүй хөрөнгө оруулалт болсон байна. Мөн 2022 оны Төсвийн тухай хуульд дахин 250.0 сая төгрөгийн Ахмадын өргөөний барилга баригдахаар төсөв батлагдсан байна. Энэ төсөл, арга хэмжээг зогсоох талаар саналыг ҮАГ-т хүргүүлэхээр шийдвэрлэв.

Дээр дурдсанаас бусад хөрөнгө оруулалтын хувьд хэрэгцээ шаардлагад нийцсэн төсөл, арга хэмжээ байна.

Шинээр хэрэгжүүлэхээр батлагдаж, эрх шилжиж ирсэн 5,262.8 сая төгрөгийн 28 ТАХ-үүд бүгд зураг, төсөвгүйгээр УИХ-аар хэлэлцэгдэж 2021 оны Төсвийн тухай хуулиар батлагдсан нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4³ дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.11⁴ заалттай тус тус нийцэхгүй байна.

Эрх шилжин ирсэн 22,193.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 41 төсөл арга хэмжээнд 2021 онд 13,095.0 сая төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсан байна. Тайлант онд хэрэгжиж дуусах 14,416.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 31 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг



бүрэн олгохоор төсвийг баталсан байна. Харин 2022 онд үргэлжлэн хэрэгжих 7,777.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 10 төсөл арга хэмжээнд 26%-ийн санхүүжилт буюу 1,990.0 сая төгрөг олгохоор баталсан байна.

Үүнээс үндэслэн төсөл арга хэмжээний санхүүжилтийг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож баталсан байна гэж дүгнэлээ.

Аж ахуйн нэгжийн барьсан стандартын шаардлага хангахгүй барилгыг Улсын төсвийн хөрөнгөөр худалдан авч тухайн төсөл, арга хэмжээнд зориулан тендерийг зохион байгуулж байгаа нь хөрөнгө оруулалтын чанар, хэрэгцээ шаардлага, үр дүн, үр ашигт нөлөөлөхөөс гадна худалдан авах ажиллагаанаас зайлсхийж хуулийн этгээдэд давуу байдал үүсгэсэн шинжтэй байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24, 33 дугаар зүйлийн 33.2.6⁵-т зааснаар хөрөнгө оруулалтад тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих, хүрэх үр дүн, хүчин чадал нь тодорхой нэршлээр заагдсан төсөл арга хэмжээг батлахаар заасан байдаг. Энэ шинжээр авч үзвэл 2021 оны Төсвийн тухай хуульд хөрөнгө оруулалтын шинж чанарыг бүрэн илэрхийлэхгүй хүрэх үр дүн нь тодорхойгүй дараах 4 төсөл арга хэмжээ байна. Үүнд:

1. Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл, Жаргалант, Галт, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Их-Уул, Рашаант сум/ - 633.0 сая, /Засгийн газрын 2008 оны 7 дугаар тогтоолоор баталсан 2008-2015 онд хэрэгжүүлэх “Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр мөн эсэх нь тодорхойгүй/

³ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

⁴ 32.1.11. зураг төсөлгүй барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахгүй байх;

⁵ 33.2. Төсөвт дараах зүйлийг тусгаж, батална: ... 33.2.6. хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар /нэр, байршил, хүчин чадал, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн/;

2. Боловсрол, соёлыг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл/ - 300.0 сая /ийм нэртэй хөтөлбөр батлагдсан эсэх нь тодорхойгүй/
3. Дархадын хотгорын цөлжилтийг бууруулах, Цойцон нуурыг нөхөн сэргээх /Хөвсгөл, Ренчинлхүмбэ сум/ /нөхөн сэргээлт хийсэн хийсэн ажлыг байгууллагын өмчлөлд тусгах боломжгүй/
4. Гэр хорооллын хөрсний бохирдлыг багасгах эко ариун цэврийн байгууламж /Хөвсгөл, Мөрөн сум 300.0 сая төгрөгийн төсөвтэй/

Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр, Боловсрол соёлыг дэмжих хөтөлбөр гэсэн төсөл арга хэмжээний хүрэх үр дүн, хийгдэх ажил нь тодорхойгүй учир аймгийн Засаг даргаас техникийн тодорхойлолт батлан хэрэгжүүлсэн байна. Техникийн тодорхойлолт боловсруулахдаа Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл, Жаргалант, Галт, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Их-Уул, Рашаант сум/-ийг дараах байдлаар 12 багц /хүснэгт№8-аар харуулав/ болгон задалсан байна.

Хүснэгт № 7

Багцын дугаар	Багцын нэр	Төсөвт өртөг /сая төгрөг/
1	Ёслол хүндэтгэлийн өргөөний тохижилт, тоног төхөөрөмж худалдан авах /Улаан-Уул сум/	10.0
2	Өл, Тоомын давааны гүүрнүүдийг засварлах, үерийн далан барих /Улаан-Уул сум/	60.0
3	Бэлчээрийн худаг /Улаан-Уул сум Мунгараг баг Байцын ар/	25.0
4	Багийн төвийн барилга барих /Тариалан сум, Таван толгой баг/	40.0
5	Багийн Засаг дарга нарыг тоног төхөөрөмжөөр хангах	70.0
6	Ундны үс зөөвөрлөх авто машин худалдан авах /Цэцэрлэг сум, 7 дугаар баг/	50.0
7	Оёдлын цехийн тоног төхөөрөмж худалдан авах /Хөвсгөл/	100.0
8	Багийн засаг дарга, багийн эмчийг унаажуулах /Хөвсгөл/	82.0
9	Үлийн цагаан оготно устгалын багаж худалдан авах /Цэцэрлэг, Цагаан-Уул, Шинэ-Идэр сум/	55.0
10	Таван ханатай гэр худалдан авах /Хөвсгөл/	45.0
11	Малын арьс, шир боловсруулах тоног төхөөрөмж худалдан авах /Баянзүрх, Эрдэнэбулган сум/	40.0
12	Ногоон тэжээлийн үр худалдан авах /Хөвсгөл, Галт, Жаргалант, Их-Уул, Цэцэрлэг, Цагаан-Уул, Улаан-Уул/	56.0
Нийт		633.0

Багц болгон задалж техникийн тодорхойлолт батлахдаа захиалагч нь төсөл арга хэмжээний хуульд заагдсан байршлыг бүрэн өөрчилсөн нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах,тайлагнах журам”-ын 4.1.33⁶, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжихгүй, хөрөнгө оруулалтын шинж чанаргүй Таван ханатай гэр худалдан авах /Хөвсгөл/ төсөл, арга хэмжээ хэрэгжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24⁷ дахь заалттай тус тус нийцэхгүй байна.

Мөн техникийн тодорхойлолтыг боловсруулахдаа анх төсөвлөсөн төсөл, арга хэмжээний үр дүнгээ бууруулсан, техникийн үзүүлэлтийг хангалтгүй тодорхойлсон, үр ашиг багатай тоног, төхөөрөмж авахаар төлөвлөсөн зэрэг ажлын хариуцлагагүй байдал гаргасан байна. Тухайлбал:

- ❖ Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр-багц-8: Багийн засаг дарга, багийн эмчийг унаажуулах /Хөвсгөл/ төсөл арга хэмжээгээр худалдан авах мотоциклийг зах зээлийн боломжит үнэ, үнэлгээг үндэслэн техникийн тодорхойлолт боловсруулаагүй тул өөрчлөгдөж тоо хэмжээ, үр дүн багассан,
- ❖ Боловсрол соёлыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд сумдын Соёлын төвүүдэд нийлүүлэгдсэн цахилгаан даралтат хөгжим нь мэргэжлийн түвшинд ашиглах боломжгүй, хянах дэлгэц нь хятад хэлээр тул ашиглахад хүндрэлтэй,
- ❖ Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр-багц-11: Малын арьс, шир боловсруулах тоног төхөөрөмж худалдан авах /Баянзүрх, Эрдэнэбулган сум/ төсөл, арга хэмжээ нь

⁶ 4.1.33.Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр, байршлыг солих, хүчин чадлыг өөрчлөх, хуулиар батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер шалгаруулалт зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэхийг хориглоно.

⁷ 4.1.24.“хөрөнгө оруулалт” гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;

орон нутагт хэрэгцээ шаардлага багатай байгаа нь 2020 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Малын арьс, өлөн боловсруулах тоног төхөөрөмж /Хөвсгөл, Жаргалант, Галт, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Их-Уул, Рашаант сум/ төсөл арга хэмжээгээр сумдад нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн ашиглалтгүй байгаагаас харагдаж байхад дахин хэрэгжүүлсэн.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.1.3⁸-т заагдсан чиг үүргээ Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс хангалтгүй хэрэгжүүлсэнтэй холбоотой байна. Төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг чиг үүргийн хэлтэс боловсруулалгүй хөрөнгө оруулалт хийгдэх салбарын мэргэжилтэн, байгууллагаар хийж ажилласан байна. Үүний улмаас төсөл, арга хэмжээний хөрөнгө оруулалтын үр дүн багасах, хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл арга, хэмжээ хэрэгжих зэрэг сөрөг үр дүн гарсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээнүүдэд орон нутагт хэрэгцээ шаардлага багатай, зураг, төсөвгүй, ТЭЗҮ-гүй, хүрэх үр дүн нь тодорхойгүй, хөрөнгө оруулалтын шинж чанартай бус, төсвийн ерөнхийлөн захирагчийн саналд үндэслээгүй төсөл арга хэмжээнүүд батлагдсан байгаагаас үндэслэн хууль тогтоох байгууллага нь төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталсан байна гэж дүгнэлээ.

БҮЛЭГ Б:

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ 78 ХУВИЙН ГҮЙЦЭТГЭЛТЭЙ БАЙНА.

Б.1 Зураг төсвийн зөвлөх үйлчилгээ хийлгэх, үнэлгээний хороо байгуулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах ажиллагаанд хугацаа алдсанаас төсөл, арга хэмжээний хэрэгжилт удааширсан байна.

Засгийн газар, Төсвийн ерөнхийлөн захирагчдаас Хөвсгөл аймгийн хэмжээнд нийт 11,068.9 сая төгрөгийн 30 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг 2021 онд шилжүүлсэн байна.

Эрх шилжүүлсэн шилжүүлсэн хугацаа, шийдвэр, төсөвт өртгийн хэмжээг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №8

Д/д	Эрх шилжүүлсэн ТЕЗ	Огноо	Дугаар	Шийдвэр	Төсөвт өртөг /сая төгрөг/	Тоо
1	Засгийн газар	2020.01.22	21	Тогтоол	650.0	2
2	Засгийн газар	2021.01.20	15	Тогтоол	9,055.9	18
3	ЗГХЭГД	2021.01.15	04	Тушаал	1,033.0	1
4	БШУС	2021.01.18	A/13	Тушаал	270.0	6
		2021.04.23	A/154	Тушаал	20.0	2
6	Хөвсгөл аймаг дахь Нисэх буудлын дарга	2021.05.07	59	Албан бичиг	40.0	1
	Нийт				11,068.9	30

Монгол улсын 2021 оны Төсвийн тухай хууль 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан бөгөөд Сангийн сайдын 2018 оны 281 тоот тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.13⁹-т зааснаар төсөв батлагдсанаас 60 хоногийн дотор эрх шилжүүлэх ёстой бөгөөд нийт эрх шилжүүлсэн хугацаанаас үзэхэд төсөл, арга хэмжээг хэрэгжих боломжтой хугацаанд эрх шилжүүлсэн байна.

⁸ 2.1.3.Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн санхүүжилт, хэрэгжилт, гүйцэтгэл, хяналтын үйл ажиллагаа, үр дүнг хариуцаж ажиллана.

⁹ Захиалагч хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэгт заасны дагуу эрх шилжүүлэх тохиолдолд төсөв батлагдсанаас хойш 60 хоногийн дотор, хэрэв тодотгол орсон тохиолдолд батлагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор тус тус холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн байна.

Эрх шилжиж 2021 онд худалдан авах ажиллагаа явагдах 30 төсөл арга хэмжээний 7 төсөл арга хэмжээг 31 багц болгон задалж нийт 54 худалдан авах ажиллагааг 2021 онд зохион байгуулж 52 гүйцэтгэгч сонгон шалгаруулж 2 ХАА амжилтгүй болсон байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны 44%-ийг 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс хойш зарлаж, гэрээний 65 хувь буюу 34 гэрээг гүйцэтгэгчтэй хагас жилээс хойш байгуулсан байна. Гэрээ байгуулсан хугацааг хүснэгтээр харуулав.

Хүснэгт №9	
Гэрээ байгуулсан сар	Гэрээ байгуулсан тоо
2021 оны 04 дүгээр сард	3
2021 оны 05 дугаар сард	8
2021 оны 06 дугаар сард	7
2021 оны 07 дугаар сард	9
2021 оны 08 дугаар сард	13
2021 оны 09 дүгээр сараас хойш	12
Нийт	52

Худалдан авах ажиллагаа нь дараах хүчин зүйлсээс шалтгаалж удааширсан байна. Үүнд:

1. Эрх шилжин ирсэн төсөл арга хэмжээ нь зураг төсөвгүй, хүрэх үр дүн тодорхойгүй /техникийн тодорхойлолтгүй/ батлагдсан төсөл, арга хэмжээ эрх шилжиж ирсэн,
2. Үнэлгээний хороо байгуулах, гэрээ байгуулах эрх олгох, гэрээ байгуулах зэрэг үе шатанд хугацаа алдсан байна.
 - ❖ Үнэлгээний хороо байгуулахдаа дунджаар 24 хоногийн хугацаа алдсан байна. 2021 онд зохион байгуулсан 30 төсөл арга хэмжээний үнэлгээний хорооны 60%-ийг ХАА-нд төлөвлөсөн хугацаанаас 35 хоногийн дараа байгуулсан дунджаар үнэлгээний хороог 24 хоногоор хоцроож байгуулсан байна.
 - ❖ Тендерийн үнэлгээг хийж гэрээ байгуулах эрх олгоход дунджаар 10 хоног, гэрээ байгуулахад 13 хоног нийт 23 хоногийн хугацаа алдсан байна. Хавсралт 1-ээр харуулав:


Үнэлгээний хороо байгуулах, гэрээ байгуулах эрх олгох, гэрээ байгуулах зэрэгт дунджаар нийтдээ 47 хоногийн хугацаа алдсан байна.

Боловсон хүчин, техникийн чадавх, хэрэгжүүлж буй ажлын байдлыг бүрэн үнэлэлгүй хэд, хэдэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр нэг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

Тайлант онд Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид улсын төсвийн хөрөнгө оруулалтын 30 /багц болгон задалснаар тооцож үзвэл 54/ төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа эрх шилжиж ирсэн бөгөөд үүнд 54 худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

ХАА-г босго үнэд үндэслэн тендер шалгаруулалтад мөрдөх журмыг хуулийн дагуу сонгон хэрэгжүүлж ажилласан байна. Худалдан авах ажиллагаанд мөрдсөн журмыг графикаар харуулав. /график №1/

ХАА-нд мөрдөгдсөн журам



Төсөвт өртөг нь 11,070.0 сая төгрөгийн 30 худалдан авах ажиллагаанд 10,368.2 сая төгрөгийн гэрээ байгуулах эрх олгон 651.1 сая төгрөгийн тендерийн хэмнэлт гаргаж ажилласан байна.

Олон нийтийн ил тод байдлыг хангах зорилгоор зарласан бүх тендерийг цахим хэлбэрээр зарласан бөгөөд шууд гэрээ байгуулах нэг худалдан авах ажиллагаанд үнийн саналыг уламжлалт хэлбэрээр авсан байна.

Худалдан авах ажиллагаанд хууль, журмын мөрдөлттэй холбоотой дараах зөрчил дутагдлууд илэрч байна. Үүнд:

1. Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл, Жаргалант, Галт, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Их-Уул, Рашаант сум/ төсөл арга хэмжээний үнэлгээний хорооны гишүүн Ц.Ганболд, Хавдрын эрт илрүүлгийн төвийн барилга худалдан авах /Хөвсгөл, Мөрөн сум/ төсөл арга хэмжээний үнэлгээний хорооны гишүүн Ч.Лхагвасүрэн, Дотуур байрны их засвар /дулаалга, сантехникийн/ Хөвсгөл, Арбулаг сум/ ажлын үнэлгээний хорооны гишүүн Ж.Улаанбаатар гэх гишүүд үнэлгээний хороонд томилогдохдоо үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг гаргаагүй байгаа нь Сангийн сайдын 2014 оны "Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам"-ын 2.4, Сангийн сайдын 2021 оны 103 дугаар тушаалаар батлагдсан "Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орох иргэний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам"-ын 2.19, 3.12 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.
2. Халуун усны барилга /Хөвсгөл, Тариалан сум/ төсөл арга хэмжээний үнэлгээний хорооны 1 гишүүн, Төмс, хүнсний ногоо тариалдаг хөдөөгийн багуудыг эрчим хүчинд холбох /Хөвсгөл, Бүрэнтогтох сум, Их-Уул, Эрчим баг/ төсөл арга хэмжээний үнэлгээний хорооны 1 гишүүн ашиг сонирхлын зөрчил илэрхийлэх мэдэгдэл гаргаагүй байна. "Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орох иргэний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам"-ын 2.20 дахь заалттай нийцээгүй байна.
3. Захиалагч нь Дотуур байрны их засвар /дулаалга, сантехникийн/ Хөвсгөл, Арбулаг сум/ ХАА-ны үнэлгээний хороонд А3 сертификатын хугацаа дууссан Б.Батзаяаг томилон ажиллуулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь заалтыг зөрчсөн байна.
4. Захиалагч нь Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл, Жаргалант, Галт, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Их-Уул, Рашаант сум/ төсөл арга хэмжээний "багц-8: Багийн засаг дарга, багийн эмчийг унаажуулах" техникийн тодорхойлолтыг боловсруулахдаа эхний удаа зах зээлийн үнээс хэт доогуур буюу 35 мотоциклыг 2,340.0 мянган төгрөгөөр авахаар техникийн тодорхойлолт боловсруулсан бол тендерт оролцогчгүйн улмаас 2021.08.24-нд техникийн тодорхойлолтыг дахин боловсруулахдаа зах зээлийн үнээс 500.0 мянган төгрөгөөр их үнээр буюу 3,280.0 мянган төгрөгөөр 25 мотоцикл авахаар техникийн тодорхойлолтыг боловсруулсан байна. Зах зээл дээр мотоцикл Мустанг загварын хятад мотоцикл нь 2,780.0 мянган төгрөгийн үнэлгээтэй байхад техникийн тодорхойлолтыг ингэж боловсруулсан байгаа нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалттай нийцээгүй байна.
5. Спорт заал худалдан авах /Хөвсгөл, Жаргалант сум/ төсөл арга хэмжээний гүйцэтгэгчээр 0.4 сая төгрөгийн татварын өртэй Денсфорист ХХК шалгаруулсан нь ТББ-ийн ТООЗ-ийн 31.3, өгөгдлийн хүснэгтийн 4.2.2, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 27.1.3, 27.4 дэх заалтуудтай нийцээгүй байна.
6. Цэцэрлэгийн барилга худалдан авах /Хөвсгөл, Жаргалант сум/ арга хэмжээний гүйцэтгэгчээр сүүлийн 3 жилээс 2018 онд ашиггүй ажилласан гүйцэтгэгч шалгаруулсан байгаа нь Тендерт оролцогчдод өгөх зөвлөмжийн 18.2.д, ТШӨХ-ийн 18.2.д, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 27.1.3, 27.4 дэх заалтуудтай нийцээгүй байна.
7. Бэлчээрийн худаг /Хөвсгөл, Тариалан, Тосонцэнгэл, Цэцэрлэг сум/, "Шинэ хөдөө" төсөл /Хөвсгөл/ багц-6 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчээр Гүний худгийн цооног өрөмдөх зөвшөөрөлгүй компани шалгаруулсан байгаа нь ТШӨХ-ийн 1.1.Л.17, ТООЗ-ийн 1.1, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 27.1.3, 27.4 дэх заалтуудтай нийцээгүй байна.
8. Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр-багц-4: Багийн төвийн барилга барих /Тариалан сум, Таван толгой баг/, Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр-багц-6: Ундны ус зөөвөрлөх авто машин худалдан авах /Цэцэрлэг сум, 7 дугаар баг/, Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр-багц-8: Багийн засаг дарга, багийн эмчийг унаажуулах /Хөвсгөл/, Нийтийн халуун усны барилга /Хөвсгөл, Баянзүрх, Алаг-Эрдэнэ сум/ багц 1, багц 2 гэсэн 5 төсөл арга хэмжээнд "Төрөлх мөрөн" ХХК, Ахмадын төвийн барилга /Хөвсгөл, Баянзүрх, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сум/ багц -2, багц-3 2 төсөл, арга хэмжээнд "Тэмээн" ХХК-г шалгаруулахдаа хүн-хүчний, техникийн чадавх, хэрэгжүүлсэн болон одоо хэрэгжүүлж буй ажлын гүйцэтгэл зэргийг хангалтгүй үнэлсэн байгаа нь

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.7.2¹⁰, 14 дүгээр зүйлийн 14.7¹¹, 14.8¹² дахь заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Худалдан авах ажиллагаанд тендерийн баримт бичгийн шалгуур, шаардлагыг хангаагүй болон боловсон хүчин, техникийн чадавх, хэрэгжүүлж буй ажлын байдлыг бүрэн үнэлэлгүй хэд хэдэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр нэг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан, худалдан авах ажиллагааны хууль, журмыг бүрэн мөрдөхгүй байгаа зэрэг зөрчилтэй зүйлс илэрч байгаа тул худалдан авах ажиллагааны хууль журмыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна гэж дүгнэлээ. Иймд дээрх зөрчлүүдтэй холбогдуулан үнэлгээний хорооны дарга, нарийн бичгийн даргад **хариуцлага тооцох албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

Худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичгийг Сангийн сайдын баталсан жишиг тендерийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж баталсан байна.

ТЕЗ худалдан авах ажиллагааны тайланг алдаатай тайлагнасан байна. Худалдан авах ажиллагааны жилийн тайланг аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн 1/130 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлж хуулийн хугацаанд нь тайлагнасан байна.

Жилийн тайланд Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр-багц-3: Бэлчээрийн худаг /Улаан-Уул сум Мунгараг баг Байцын ар/ төсөл арга хэмжээний гүйцэтгэгчээр шалгарсан “Бимм” ХХК нь гэрээ байгуулаагүй, төсөл, арга хэмжээг гүйцэтгэхээс татгалзсан байхад ХАА-ны тайланд гэрээ байгуулсан мэтээр тайлагнаж 25.0 сая төгрөгийн, Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр багц-7 Оёдлын цехийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажил нь гэрээний үнийн дүн 6.1 сая төгрөгийн нийт 31.1 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна.

Б.2 Захиалагч нь гүйцэтгэгч байгууллагын гэрээний хугацаа дууссан байхад гэрээнд өөрчлөлт оруулаагүй, алданги тооцоогүй, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын гэрээг үнэлж, дүгнээгүй байна.

Захиалагч, гүйцэтгэгч нь төсөл, арга хэмжээний гэрээний хугацаа дууссан байхад гэрээнд өөрчлөлт оруулаагүй, гэрээний хугацаанд сунгалт хийгээгүй, гүйцэтгэгч байгууллагатай алданги тооцоогүй байна. /Хавсралт 1-ээр харуулав./ Гэрээнд заасан хугацаанд ажлаа гүйцэтгээгүй, гэрээний хугацааг сунгаагүй дээрх зөрчилд үндэслэн аудитаар 5.5 сая төгрөгийн **төлбөрийн акт тогтоохоор** шийдвэрлэв.

Хөвсгөл аймгийн хэмжээнд хөрөнгө оруулалтын бодлогын нэгдсэн судалгаа, мэдээллийн сан байхгүйгээс хөрөнгө оруулалтууд хэрэгцээ шаардлага багатай газар нийт 1,295.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн нь хөрөнгө оруулалтын үр ашиг, үр нөлөөг бууруулахад хүрч байна. Тухайлбал:

ЭХС-ын багц: Багийн сэргээгдэх эрчим хүчний холболт /Хөвсгөл, Төмөрбулаг сум/-ын хүрээнд 257.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй нарны зайн хураагууртай сэргээгдэх эрчим хүчийг Төмөрбулаг сумын Тээл багийн төвд 2020 онд суурилуулсан бөгөөд ашиглалтад хүлээн авсан цагаас эхлэн 2 айл /хоёр хэрэглэгч/ эрчим хүчний эх үүсвэрийг ашиглаж байна. Сэргээгдэх эрчим хүчийг ашиглалтыг сайжруулах, хэрэглэгчдийг нэмэх бодлогын арга хэмжээг орон нутгийн удирдлагуудаас огт шийдвэрлээгүй бөгөөд хариуцагч байгууллага, хадгалалт хамгаалалт тодорхой бус байна.

¹⁰ 8.7.2.захиалагч тендерийн урилга болон тендерийн баримт бичигт багцуудын талаарх мэдээлэл, тендерт оролцогч нэг буюу хэд хэдэн, эсхүл бүх багцад саналаа ирүүлж болохыг заах;

¹¹ 14.7.Захиалагч шаардсан тохиолдолд тендерт оролцогч хэрэгжүүлж байгаа буюу хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаархи мэдээллийг бичгээр ирүүлнэ.

¹² 14.8.Захиалагч энэ зүйлийн 14.7-д заасан мэдээллийг тендерт оролцогчийн тухайн гэрээг гүйцэтгэх санхүүгийн болон техникийн чадавхийг үнэлэхэд харгалзан үзнэ.



Багийн сэргээгдэх эрчим хүчний холболтын зураг-2

Багийн төвийг эрчим хүчээр холбох /Хөвсгөл, Их-уул сум мандал баг сараалж баг/ ажлын хүрээнд 2020 онд 199.7 сая төгрөгийн эрчим хүчний холболтын ажлын гүйцэтгэсэн бөгөөд тус багийн төвд хэрэглэгч багатай, одоог болтол цахилгааны холболт хийгдээгүй байна.



Их-Уул сумын Мандал, Сараалж багийг эрчим хүчээр холбох ажлын зураг-3

ХНХС-ын багц: Ахмадын өргөөний барилга /Хөвсгөл, Шинэ-Идэр сум/-ын хүрээнд 2021 оны улсын төсвийн эрх шилжсэн хөрөнгө оруулалтаар 77.2 сая төгрөгийн ахмадын өргөө баригдсан бөгөөд 2022 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дахин 250.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Ахмадын төвийн барилга баригдаж байна. Энэ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээг бодлогын хэмжээнд төлөвлөхгүй, үр ашигтай байдлаар зарцуулахгүй байгааг харуулж байна.



Ахмадын өргөөний барилгын зураг-4



Жаргалант сумын хүүхдийн цэцэрлэгийн барилгын зураг-5

БШУЯС-ын багц: Цэцэрлэгийн барилга худалдан авах /Хөвсгөл, Жаргалант/ ажлын хүрээнд 450.0 сая төгрөгийн төсөвт, өртөгтэй цэцэрлэгийн барилга худалдаж авсан байна. Тус барилга нь “Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2017 оны 179 дүгээр тушаалаар батлагдсан Сургалт-хүмүүжлийн байгууллагад мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм”-д заасан ерөнхий шаардлагуудыг хангахгүй байхад тендер зохион байгуулан, улсын комисс ажиллан хүлээж авсан байна. Мөн улсын комиссоор өгөгдсөн үүрэг даалгавраар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт хангалтгүй байна.



Арьс шир илдэх төхөөрөмж зураг-6

ЗГХЭГД-ын багц: Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл, Жаргалант, Галт, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Их-Уул, Рашаант сум/-ийн хүрээнд 2020-2021 онуудад тус бүр нь 19.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 ширхэг 138.9 сая төгрөгийн арьс шир илдэх тоног төхөөрөмж худалдан авч сумдад нийлүүлсэн бөгөөд тус төхөөрөмж нь орчин үеийн арьс, шир илдэх төхөөрөмжөөс хүчин чадал муутай, ажиллагаа ихтэй, хэрэгцээ шаардлагад нийцэхгүй тул ашиглагчгүй болсон байна. Тиймээс тус төхөөрөмжүүд нийлүүлэгдсэн цагаас хойш огт ашиглалтгүй, цаашид хэрхэн ашиглах талаар тодорхой шийдвэргүй сумын агуулахад хураалттай байна.

Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл, Жаргалант, Галт, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Их-Уул, Рашаант сум/ IV.1.29/ багц-8-ийн хүрээнд тус бүр нь 3.3 сая төгрөгийн үнэ бүхийн 25 ширхэг нийт 82.0 сая төгрөгийн Мустанг-5 мотоцикл худалдан авч сумдын багийн эмч болон багийн дарга нарт нийлүүлсэн байна. Тус мотоциклуудыг нийлүүлсэн Төрөлх Мөрөн ХХК нь нэг бүрийг зах зээлийн үнэлгээнээс ойролцоогоор 0.5 сая төгрөгөөр нийт 12.5 сая төгрөгөөр илүү дүнтэйгээр гэрээ байгуулсан бөгөөд хүчин чадлын хувьд үзүүлэлт муутай байна. Иймд цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

Захиалагч, зураг төсөл зохиогч байгууллагаас барилга угсралтын ажлын явцад хяналт хийх давтамж бага хяналтаар өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг эргэж шалгахгүйгээс зураг, төсөвт тусгагдсан ажил бүрэн хийгдээгүй барилгыг улсын комисс хүлээн авч ашиглалтад оруулсан байна. Тухайлбал:

- ❖ Тариалан сумын Халуун усны барилгыг 144.9 сая төгрөгийн дүнтэй гэрээ байгуулан Голден прогресс ХХК гүйцэтгэсэн бөгөөд зураг төсөвт тусгагдсан гадна тохижилтын ажил болон комиссын хурлын тэмдэглэлээр өгсөн ажил хийгдээгүй байхад 2021 оны 12 сарын 14-ний өдрийн ББКД-67-52/21 тоот комиссын актаар хүлээн авсан байна.
- ❖ Хүүхэд залуучуудын цэцэрлэгт хүрээлэн, биеийн тамирын талбай /Хөвсгөл, Мөрөн сум, 10, 11, 12, 13, 14-р баг/ төсөл арга хэмжээг гүйцэтгүүлэхээр Хөвсгөл Мон Трэйвел ХХК-тай 398.2 сая төгрөгийн гэрээ байгуулсан бөгөөд чийрэгжүүлэх төхөөрөмж 5 ширхэг дутуу, жижиг гэрэл 4 ширхэг суурилагдаагүй, том гэрэл, 4 ширхэг суурилагдаагүй байхад 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн БХБЯ/202001098/1.3.12 тоот комиссын актаар хүлээн авсан байна.
- ❖ Мөрөн сумын 3 дугаар цэцэрлэгийн барилгын их засварын ажлыг гүйцэтгүүлэхээр Эндус-Эрхэт ХХК-тай 27.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан бөгөөд дээврийн ус цуглуулах ховилыг зураг, төсөвт тусгагдсаны дагуу хийгээгүй, салбар цэцэрлэгийн цонхыг солихдоо хуучин модон цонхны суурин дээр хийсэн зай, завсартай байхад 2021 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр “Барилга захиалагчийн хяналтын төв”-өөс Захиалагчийн барилгын хяналтын нэгдсэн дүгнэлт гаргаж, 2021 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн ББКД-67-24/21 тоот комиссын актаар хүлээн авсан байна.
- ❖ Цагаан-Үүр сумын Цэцэрлэгийн барилгын их засвар /Хөвсгөл, Цагаан-Үүр сум/ ажлыг гүйцэтгүүлэхээр Бумбах ХХК-тай 73.9 сая төгрөгийн гэрээ байгуулсан бөгөөд дээврийн агааржуулалт дутуу хийгдсэн, цахилгааны ажил хангалтгүй, шалны хулдаас зурагт заасны дагуу хийгдээгүйгээс чанаргүй болсон байхад улсын комисс хүлээн авсан.
- ❖ Цэцэрлэгийн барилга худалдан авах /Хөвсгөл, Жаргалант сум/ төсөл, арга хэмжээнд ажлын хэсгийн тэмдэглэлээр өгсөн ажил дутуу байхад улсын комисс хүлээж авсан.
- ❖ Ренчинлхүмбэ сумын 320 хүүхдийн сургуулийн барилгын ажлыг гүйцэтгэл дутуу байхад улсын комисс ажиллаж барилгыг хүлээн авсан.

- ❖ Боловсролын соёлыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Тариалан сумын Хүүхдийн цэцэрлэгт нийлүүлэгдсэн 1.9 сая төгрөгийн 1 ширхэг суурин компьютер ажиллахгүй байна.

Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж буй байгууллагын зүгээс байнгын ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтэд тавих хяналт хангалтгүй байгаа нь Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1¹³, 46 дугаар зүйлийн 46.1.2¹⁴, 43.3¹⁵, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 8.2.2¹⁶-д заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд аудитын дүнд үндэслэн хэрэгжилт дутуу байхад хүлээж авсан улсын комиссын гишүүд болон “Барилга захиалагчийн хяналтын төв”-ийн захиалагчийн хяналтын дүгнэлт гаргасан албан хаагчдад зөрчлийг ариллуулах тухай **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 6,932.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 45 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 249.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй, 6,167.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 14 төсөл арга хэмжээний хэрэгжилт дутуу дараа онд шилжсэн байна. Хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн техник, тоног төхөөрөмжүүд техникийн тодорхойлолтод заасны дагуу бүрэн нийлүүлэгдсэн байна.

Аж ахуйн нэгжүүд боловсон хүчин, хөрөнгө санхүүгийн нөөцөөр хангагдсан хэдий ч жилд 2-оос дээш төсөл, арга хэмжээг нэгэн зэрэг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй бөгөөд зарим аж ахуйн нэгжүүд 4 хүртэл барилга, байгууламжийн ажлын гүйцэтгэж байгаа нь төсөл, арга хэмжээний хэрэгжилт удаашрах, төлөвлөсөн хугацаанд үр дүнгээ өгөхгүй байхаас гадна хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж байна. Хоёроос дээш төсөл, арга хэмжээ хэрэгжүүлж буй аж, ахуйн нэгжийн мэдээллийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-10

№	Гүйцэтгэгч компани	Гэрээний тоо		Гэрээний нийт тоо	Нийт гэрээний дүн /сая.төг/
		Барилга, их засвар, худаг	Бараа, тоног төхөөрөмж		
1	Төрөлх Мөрөн ХХК	2	3	5	465.1
2	Бумбах ХХК	4	-	4	418.2
3	Хөвсгөл геологи ХХК	4	-	4	369.7
4	Тэмээн ХХК	3	-	3	1,682.9
5	Ашид Буян ХХК	-	3	3	499.6
6	Уул-Өвгөд ХХК	2	-	2	3,231.2
7	Тэргүүн сонголт ХХК	-	2	2	713.2
8	Баяншувуут ХХК	-	2	2	367.8

Гүйцэтгэгч нь 2-оос дээш барилга байгууламж авсан боловч хэрэгжилт удаашралтай, хэрэгжилт хангалтгүй байгаа төсөл, арга хэмжээг жишээ болгож дурдав. Тухайлбал:

- ❖ Төрөлх Мөрөн ХХК нь барилга, техник тоног төхөөрөмжийн 5 тендерт шалгарч гэрээ байгуулсан хэдийн Алаг-Эрдэнэ болон Баянзүрх суманд баригдах 293.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй халуун усны барилга одоог болтол эхлээгүй байна.
- ❖ Тэмээн ХХК нь Цагаан-Үүр суманд 1,197.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй ЗДТГ, 240.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй ахмадын өргөөний барилга, Чандмань-Өндөр суманд 245.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй ахмадын өргөөний барилгыг тус тус гүйцэтгэж байгаа бөгөөд ахмадын өргөөний барилгуудын гүйцэтгэл хангалтгүй байна.

¹³ Барилга байгууламж дараахь шаардлагыг хангасан байна.

¹⁴ Энэ хуулийн 33.1.18-д заасан журмын дагуу барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх;

¹⁵ Хөрөнгө оруулагч, захиалагч ашиглалтад оруулсан барилга байгууламжийн газрын зөвшөөрөл, тэг тэнхлэг таталтын акт, зураг төсөл, ил, далд ажлын акт, гадна шугам сүлжээний гүйцэтгэлийн зураг, барилгын ажлын явцад захиалагч, зохиогч, улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын чанар, аюулгүй байдлын талаар гаргасан дүгнэлт, ашиглалтад оруулсан баримт бичгийг тухайн барилга байгууламжийг ашиглалтад оруулснаас хойш 30 өдөрт багтаан холбогдох архивт шилжүүлнэ.

¹⁶ 8.2.2. энэ дүрмийн 5.1, 6.1-д заасан шаардлага хангаагүй, 8.1-д заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангагдаагүй тохиолдолд татгалзсан дүгнэлт.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй барилга байгууламжаас хугацаандаа ашиглалтад ороогүй олон жил үргэлжилж буй барилгын гүйцэтгэгч нартай хариуцлага тооцож ажиллах шаардлагатай байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжихээр ажил нь эхлээд одоог хүртэл дуусаагүй орон нутагт эрх шилжээгүй дараах барилгууд байна. Үүнд:

- ❖ Улаан-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн барилгын ажлыг 2013 оноос одоог хүртэл ашиглалтад ороогүй жил бүр батлагдсан төсвийг нэмэгдүүлдэг, гүйцэтгэл 80 хувьтай байна.
- ❖ Ренчинлхүмбэ сумын 320 хүүхдийн сургуулийн барилгын ажлыг 3,496.6 сая төгрөгийн гэрээний үнийн дүнгээр Хөвсгөл суварга ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд 2018 оноос одоог хүртэл ашиглалтад ороогүй гүйцэтгэл 80 хувьтай байна.
- ❖ Төмөрбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлыг 1,230.0 сая төгрөгийн гэрээний үнийн дүнгээр Шидэт гал ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд 2019 оноос одоог хүртэл дуусаагүй барилгын гүйцэтгэл 20 хувьтай байна. Төсөл, арга хэмжээг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэхгүй, удаашралтай байгаа барилгын гүйцэтгэгч нарт холбогдох арга хэмжээ авч ажиллахыг ҮАГ-т хүргүүлж байна.

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй барилга байгууламжийн хэрэгжилт удааширч, олон жил үргэлжилж байгаа нь дараах хүчин зүйлсээс шалтгаалж байна. Үүнд:

- ❖ Төсөл, арга хэмжээнд эдийн засаг, техник тоног төхөөрөмж, хүн хүчний нөөц хангалтгүй компанийг сонгон шалгаруулж байна.
- ❖ Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих захиалагчийн болон мэргэжлийн байгууллагын хяналт сул, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар цаг хугацаанд нь арга хэмжээ авдаггүй, гэрээний үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгжтэй хариуцлага тооцдоггүй.

Б.3 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг бодитой хянаагүйгээс хийгдээгүй ажлын гүйцэтгэлд санхүүжилт олгосон байна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 2.2¹⁷, 2.8¹⁸-д заасны дагуу аймгийн Засаг дарга “Барилга захиалагчийн хяналтын төв”-тэй 271.9 сая төгрөгийн гэрээ байгуулан захиалагчийн чиг үүргийг төлөөлүүлэн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд “Барилга захиалагчийн хяналтын төв”-өөр захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байгаа нь нэг талаасаа мэргэжлийн инженерээр хяналт тавиулж барилгын чанар үр дүн сайжрах эерэг нөлөөтэй байна. Гэвч захиалагчийн хяналтын зардлаас хяналтыг хэрэгжүүлэхээс гадна ОНӨГ-ын гэрээт албан хаагчийн цалинд 7.0 сая төгрөг, бичиг хэргийн зардалд 8.9 сая төгрөгийг, ГХБХБГ-т 28.7 сая төгрөгийг тус тус шилжүүлж барилга байгууламжийн захиалагчийн хяналтын зардлаас санхүүжүүлэх зардлын нэр төрөлд хамаарахгүй зардалд зарцуулсан байна. Иймд аудитаар **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Захиалагчийн хяналтын зардлыг Барилгын тухай хууль, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-д нийцүүлэн барилгын үе шатны ажилд хяналт хийхтэй холбоотой зардалд зарцуулж Барилга хот байгуулалтын сайдын 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 83 дугаар тушаалаар батлагдсан “Барилга захиалагчийн хяналтын талаар авах зарим арга хэмжээний тухай” тушаалыг баримталж ажиллах шаардлагатай байна.

¹⁷ Барилга байгууламжийн хөрөнгө оруулагч захиалагчийн чиг үүрэг хэрэгжүүлэх этгээдийг байнгын ажиллагаатай, эсхүл тухайн барилга байгууламжийн барилгын ажил гүйцэтгэх хугацаагаар байгуулан ажиллуулах бөгөөд Барилгын тухай хуулийн 37.2-т заасан мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх этгээдээр захиалагчийн чиг үүргийг төлөөлүүлэн хэрэгжүүлж болно.

¹⁸ Захиалагч Барилгын тухай хуулийн 37.1.4-т заасан барилгын үе шатны ажилд тавих хяналтыг хэрэгжүүлэхдээ захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдийг томилон ажиллуулна.(Энэ заалтыг Засгийн газрын 2018 оны 316 дугаар тогтоолоор нэмсэн)

Аймгийн Засаг дарга нь зөвлөх үйлчилгээ үзүүлэгч буюу үе шатны хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагатай байгуулсан гэрээг дүгнээгүй, тухайн жилд гүйцэтгэсэн ажлыг гэрээнд заасан хугацаанд үнэлээгүй, үр дүнг тооцоогүй байна.

Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжсэн зарим төсөл арга хэмжээний гүйцэтгэл дутуу, зураг төсөвт тусгагдсан ажил бүрэн хийгдээгүй, ажлын үе шатны гүйцэтгэл бодит бус байхад санхүүжилтийг бүрэн олгосон байна. Үүнд:

ЗГХЭГД багцад:

- ❖ Цагаан-Үүр сумын ЗДТГ-ын барилгын ажлыг гүйцэтгүүлэхээр Тэмээн ХХК-тай 1,197.8 сая төгрөгийн дүнгээр гэрээ байгуулсан бөгөөд ажил эхэлснээс хойш 1,063.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Аудитаар шалгахад гүйцэтгэл 65 орчим хувьтай байсан бөгөөд гүйцэтгэгчид 90 хувийн санхүүжилт олгосон байна.
- ❖ Түнэл сумын ЗДТГ-ын барилгын ажлыг гүйцэтгүүлэхээр Цэгц мандал ХХК-тай 1,197.8 сая төгрөгийн дүнгээр гэрээ байгуулсан бөгөөд гэрээнд заагдсан ажил нь бүрэн дуусаагүй байхад 1,197.8 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон, гэрээг дахин сунгаагүй байна.
- ❖ Их-Уул сумын Сургуулийн барилга, спорт заалны ажлыг гүйцэтгүүлэхээр Уул-Өвгөд ХХК-тай 3,186.2 сая төгрөгийн гэрээ байгуулсан бөгөөд гэрээнд заагдсан ажил нь бүрэн дуусаагүй байхад 3,186.2 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байна.

БХБС-ын багцад:

- ❖ Нийтийн халуун усны барилга /Хөвсгөл, Баянзүрх, **Алаг-Эрдэнэ сум**/ -ын ажлыг гүйцэтгүүлэхээр Төрөлх мөрөн ХХК-тай 144.7 сая төгрөгийн гэрээ байгуулсан бөгөөд барилгын ажил огт эхлээгүй байхад гүйцэтгэлийг бодитой эсэхийг нягтлахгүйгээр 50.0 сая төгрөгийн гүйцэтгэл гарган санхүүжилтийг олгосон байна.
- ❖ Нийтийн халуун усны барилга /Хөвсгөл, **Баянзүрх**, Алаг-Эрдэнэ сум/ -ын ажлыг гүйцэтгүүлэхээр Төрөлх мөрөн ХХК-тай 148.4 сая төгрөгийн гэрээ байгуулсан бөгөөд барилгын ажил огт эхлээгүй байхад гүйцэтгэлийг бодитой эсэхийг нягтлахгүйгээр 50.0 сая төгрөгийн гүйцэтгэл гарган санхүүжилтийг олгосон байна.
- ❖ Хүүхэд залуучуудын цэцэрлэгт хүрээлэн, биеийн тамирын талбай /Хөвсгөл, Мөрөн сум, 10, 11, 12, 13, 14-р баг/ төсөл арга хэмжээг гүйцэтгүүлэхээр Хөвсгөл Мон Трэйвел ХХК-тай 398.2 сая төгрөгийн гэрээ байгуулсан бөгөөд чийрэгжүүлэх төхөөрөмж 5 ширхэг дутуу, жижиг гэрэл 4 ширхэг суурилагдаагүй, том гэрэл, 4 ширхэг суурилагдаагүй байхад 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн БХБЯ/202001098/1.3.12 тоот комиссын актаар хүлээн авсан байна.
- ❖ Тариалан сумын Халуун усны барилгыг 144.9 сая төгрөгийн дүнтэй гэрээ байгуулан Голден прогресс ХХК гүйцэтгэсэн бөгөөд зураг төсөвт тусгагдсан гадна тохижилтын ажил болон комиссын хурлын тэмдэглэлээр өгсөн ажил хийгдээгүй байхад 2021 оны 12 сарын 14-ний өдрийн ББКД-67-52/21 тоот комиссын актаар хүлээн авсан байна.

БШУЯ-ны багцад

- ❖ Мөрөн сумын 3 дугаар цэцэрлэгийн барилгын их засварын ажлыг гүйцэтгүүлэхээр Эндус-Эрхэт ХХК-тай 27.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан бөгөөд дээврийн ус цуглуулах ховилыг зураг, төсөвт тусгагдсаны дагуу хийгээгүй, салбар цэцэрлэгийн цонхыг солихдоо хуучин модон цонхны суурин дээр хийсэн зай, завсартай байхад 2021 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр “Барилга захиалагчийн хяналтын төв”-өөс Захиалагчийн барилгын хяналтын нэгдсэн дүгнэлт гаргаж, 2021 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн ББКД-67-24/21 тоот комиссын актаар хүлээн авсан байна.

ХНХС-ын багцад:

- ❖ Чандмань-Өндөр сумын ахмадын төвийн барилга төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр Тэмээн ХХК-тай 245.1 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээ байгуулсан бөгөөд тайлант онд 65.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч ажил огт эхлээгүй байна.
- ❖ Цагаан-Үүр сумын ахмадын төвийн барилга төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр Тэмээн ХХК-тай 240.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан бөгөөд тайлант онд 70.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч ажлын гүйцэтгэл бодит бус байна.

ЭХС-ын багцад:

- ❖ Багийн төвийг эрчим хүчээр холбох /Хөвсгөл, Их-уул сум мандал баг сараалж баг/ төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр Хос Хан Хөхий ХХК-тай 199.7 сая төгрөгийн гэрээ байгуулсан бөгөөд зураг төсөвт заагдсан ажил хийгдээгүй дутуу байхад тайлант онд санхүүжилтийг бүрэн олгосон байна.

БОАЖС-ын багцад:

- ❖ Соёмбо цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажил /Хөвсгөл, Мөрөн сум/-ыг түлхүүр гардуулах 1,999.1 сая төгрөгийн үнэтэй төсөл, арга хэмжээнээс тайлант онд 200.0 сая төгрөгийн санхүүжилт авсан боловч гүйцэтгэх ажлын хугацаанд заагдсан гаднах хашааны ажил, 0.4 кВт ЦДШ-ын ажил, гадна цэвэр усны ажил хийгдээгүй байна.

“Барилга захиалагчийн хяналтын төв” нь улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг бодитой хянаагүйгээс гадна санхүүжилтийн эрхийг нээж буй аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн холбогдох албан хаагчид гүйцэтгэлийг хянахгүйгээр санхүүжилтийг олгосноос дээрх зөрчлүүд үүссэн байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.1.2.9¹⁹, 2.1.3²⁰, 2.3.2.4²¹ дэх заалттай нийцэхгүй байна. Мөн ТЕЗ буюу зөвлөх үйлчилгээ үзүүлж буй байгууллага нь Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийг бүрэн хэрэгжүүлээгүй, барилгын үе шатанд хийх хяналт сул байгаатай холбоотой байна.

Аудитаар дээрх зөрчилтэй холбогдуулан төсөл, арга хэмжээний ажил дутуу, гүйцэтгэл бодит бус байхад барилга захиалагчийн хяналтын дүгнэлт гаргасан “Барилга захиалагчийн хяналтын төв”-ийн дарга, гүйцэтгэлийг хяналгүйгээр санхүүжилтийн эрхийг нээж санхүүжилт олгосон ХОХБТХ-ийн дарга, мэргэжилтэн, зураг төсөвт тусгагдсан ажил бүрэн хийгдээгүй байхад хүлээж авсан улсын комиссын гишүүдэд **хариуцлага тооцох албан шаардлагыг** аймгийн Засаг даргад хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Б.4 Гүйцэтгэгч ажлаа хугацаанд нь гүйцэтгээгүйгээс батлагдсан санхүүжилтийг бүрэн ашиглахын тулд тухайн жилийн санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнээс 538.8 сая төгрөгийн төсөл арга хэмжээ хугацаандаа хэрэгжээгүй бөгөөд оны эцэст санхүүжилтийг орон нутгийн барьцаа хөрөнгийн “100170051350 Хө.Барьцаа ХО” тоот дансанд байршуулсан байна. Хавсралт 2-оор харуулав.

Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан хөрөнгөнөөс тайлант онд дараах төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгосон байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-11

№	Төсөл арга хэмжээний нэр	Гүйцэтгэгч компани	2021 онд олгосон /сая.төг/
1	Ренчинлхүмбэ сумын Цаг-Уурын өртөөний барилгын ажлын санхүүжилт	Бумбах ХХК	42.3
2	Аялал жуулчлал, мэдээлэл сурталчилгааны Соёмбо цогцолборын дэд бүтэц, тохижилтын багц-6		70.0
3	Жаргалант сумын сургуулийн байрны засварын ажлын санхүүжилт	Хөвсгөл булаг ХХК	36.5
4	Ренчинлхүмбэ сумын 320 хүүхдийн сургуулийн барилга угсралтын ажлын санхүүжилт	Хөвсгөл суварга ХХК	313.6
5	Цэцэрлэгийн барилга /100 ор, Хөвсгөл, Мөрөн сум/	Сант-Өндөр ХХК	143.6
6	Ундны усны худаг	Хөвсгөл геологи ХХК	68.5
НИЙТ ДҮН			674.5

19 2.1.2.9.улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төслийн гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлэх, гүйцэтгэлийн санхүүжилтийг хянан баталгаажуулах;

20 2.1.3 Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн санхүүжилт, хэрэгжилт, гүйцэтгэл, хяналтын үйл ажиллагаа, үр дүнг хариуцаж ажиллана.

21 2.3.2.4 барилга байгууламж, өргөтгөл, их засварын ажлыг байнгын ашиглалтад оруулах улсын комиссын актаар холбогдох дүрмийн дагуу ашиглалтад хүлээн авсны үндсэн дээр эцсийн санхүүжилт хүсэх;

Ренчинлхүмбэ сумын 320 хүүхдийн сургуулийн барилга угсралтын ажил нь 2019 оноос хойш одоог хүртэл дуусаагүй бөгөөд дотор цахилгаан, дотор засвар болон гадна тохижилт зэрэг ажлууд огт хийгдээгүй гүйцэтгэл 80 хувьтай байхад улсын комиссын акт үйлдэн хүлээж авсан байна. Мөн барьцаа хөрөнгийн дансанд үлдсэн 450.0 сая төгрөгийн санхүүжилтээс гүйцэтгэлийг нь бодитой хяналгүйгээр 313.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Мөн Барилгын тухай хуулийн 14.8²²-д заасны дагуу төсөл, арга хэмжээний барьцааг бүртгэх, чөлөөлөх ажлын тооцооллыг үнэн зөв хийсэн байна.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний банкны баталгааг хуульд заасан хувь хэмжээгээр байршуулж төсөл, арга хэмжээг улсын комисс хүлээн авсны дараа бүрэн олгосон байна.

Монгол Улсын барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 1/1361 албан бичгээр гэрээт ажлын гүйцэтгэлийн баталгааг гүйцэтгэсэн ажлын хувь хэмжээтэй нь уялдуулан чөлөөлөх арга хэмжээг шуурхай авч ажиллах тухай чиглэл өгсөн байна.

Орон нутгийн өмчийн газар нь орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төсвийн зарцуулалтын гүйцэтгэлд хяналт тавих, төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн бараа, ажил, үйлчилгээг хүлээн авах, данс бүртгэлд тусгах, гүйцэтгэлийн чанарын баталгааны барьцаа хөрөнгө чөлөөлөх зэрэг арга хэмжээг зохион байгуулж, гүйцэтгэл үр дүнг тайлагнах чиг үүрэгтэй. Хөвсгөл аймгийн ОНӨГ нь чиг үүргийн дагуу улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээг хүлээн авч, данс бүртгэлд тусгаж байгаа хэдий ч тайлант онд дараах зөрчлийг гаргасан байна. Үүнд:

Аймгийн ОНӨГ нь улсын төсвийн хөрөнгө, оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний зарим эд хөрөнгийг ашиглагч байгууллагад биетээр хүлээлгэж өгөлгүйгээр “Хөрөнгө бүртгэх тухай” тушаал гарган нягтлан бодох бүртгэлд бүртгүүлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл Нягтлан бодох бүртгэлийн зарчим 5.1.4 “үнэн зөв байх”, 13.6²³, 13.7²⁴ дахь заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 2 дахь заалтыг тус тус зөрчсөн, “оршин байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Тухайлбал:

Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл, Жаргалант, Галт, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Их-Уул, Рашаант сум/ IV.1.29/ багц 8-ын хүрээнд 82.0 сая төгрөгийн 25 ширхэг мотоцикл худалдаж авсан бөгөөд Хөвсгөл аймгийн орон нутгийн өмчийн газрын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдийн “Хөрөнгө бүртгэх тухай” 1/121 дүгээр тушаалаар сумдын багийн Засаг дарга, багийн эмч, хэсгийн төлөөлөгч, цагдаа нарт олгосон мотоциклийг холбогдох байгууллагуудад эзэмшүүлж 2021 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор 2021 оны санхүүгийн тайланд тусгаж тайлагнахыг зөвшөөрсөн байна. ОНӨГ-аас тайланд онд 16 мотоциклийг сумдад хүлээлгэж өгөлгүйгээр хөрөнгөд бүртгүүлсэн ч 5 сарын турш шаардлагатай албан хаагчдад хүргэгдээгүй байгаа нь төсөл, арга хэмжээний үр дүн, үр ашиг, хэрэгцээ шаардлагыг бууруулж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдэж буй техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг гэрээнд заасан хугацаанд хүлээн авсан ч УИХ-ын гишүүд өөрсдөө биечлэн ирж, өөрийн нэрийн өмнөөс үнэгүй хандив мэт ойлголтоор ашиглагч талд тарааж байгаа нь дээрх зөрчил гарах шалтгааны нэг болж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутагт бие болсон хөрөнгөд ОНӨГ-аас тавих хяналт сул байгаагаас зарим хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт алдагдаж, үр ашиг буурч байна. Тухайлбал:

²² Улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх барилга байгууламжид энэ хуулийн 14.3-т заасан хугацаанд гүйцэтгэгчээс хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн тодорхой хувийг уг хугацаа дуустал барьцаалах нөхцөлийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43.6-д заасны дагуу зохицуулна.

²³ Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.

²⁴ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.

ХХААХҮС-ын багц: Шинэ хөдөө төсөл хөтөлбөрийн хүрээнд “Махны чиглэлийн Сэлэнгэ үүлдрийн тугалтай 80 үнээ, 4 бух” нийлүүлэхээр Баяншувуут ХХК-тай 223.2 сая төгрөгийн гэрээ байгуулан барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлсэн боловч малын арчилгаа, хариулга, хашаа хороо бэлэн бус байснаас хорогдол гарсан байна. **Зураг-7**

Аудитын шалгалтаар малыг бүртгэхэд 40.5 сая төгрөгийн 22 үнээ, 19.6 сая төгрөгийн 28 бяруу, 10.0 сая төгрөгийн 2 бух нийт 70.1 сая төгрөгийн 52 мал хорогдсон байна. ОНӨГ-ын даргын 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн “Хөрөнгө бүртгэх тухай” А/103 дугаар тушаалаар төслийн хүрээнд бий болсон малыг ОНӨГ-ын бараа материалын бүртгэлд бүртгэсэн бөгөөд цаашид



малын эрүүл мэнд, хариулга маллагаа, иргэдэд түрээслэх ажлыг зохион байгуулахыг ХХААЖДҮ-ийн газрын даргад даалгасан байна. Гэвч бодит байдал дээр малыг байршуулах газар, хашаа, худаг ус, өвс, маллах малчны асуудал болон урсгал зардлыг шийдвэрлээгүй, малыг хэрхэн онд мэнд оруулах талаар зохион байгуулалттай ажил хийгдээгүйгээс дээрх хорогдол гарч төсөл, арга хэмжээний үр дүн буурахад нөлөөлсөн байна. Мөн барааны техникийн тодорхойлолтод “Сэлэнгэ” үүлдрийн үнээ нь 3-4 настай байх гэж заасан байхад нийлүүлэгдсэн үхэр дотор хөгшин хээлтэгч үнээ нэлээдгүй байсан нь барааг техникийн тодорхойлолтод заасны дагуу хүлээж аваагүйг харуулж байна.

Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хэрэгжсэн 99.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Арьс шир боловсруулах тоног төхөөрөмж нь нийлүүлэгдсэнээс хойш 2 жилийн турш зориулалтын дагуу ашиглагдаагүй, хадгалалт хамгаалалтын байдал алдагдсан үр ашиггүй байхад 2021 онд 39.6 сая төгрөгийн 2 төхөөрөмж нэмж авсан бөгөөд мөн адил ашиглалтгүй байна.

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн барилга байгууламжийн дийлэнх хэсэг нь ашиглалтад ороогүй дараа онд шилжсэн бөгөөд Эрүүл мэндийн төвийн лаборатори болон багшийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд нийлүүлэгдсэн техник, тоног төхөөрөмжийг бүрэн хэмжээгээр ашиглаж, үр дүнгээ өгч байна.

Ковид-19 цар тахал гарснаас 2021 онд ачаа тээвэр, хил, гаалийн асуудалтай холбогдуулан барилгын материалын үнэ өссөн байна. Үүний хүрээнд УИХ-ын 2021 оны 88 дугаар тогтоолын холбогдох заалтын дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний барилгын материалын үнийн өсөлтийг тооцож, дахин магадлал хийх шаардлага үүсэж гэрээнд заагдсан хугацаанд бүрэн хийгдээгүй төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдсэн байна.

Тайлант онд 9,366.4 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээ он дамжин хэрэгжсэн бөгөөд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдээгүй батлагдсан төсвийн дагуу гүйцэтгэгдсэн байна.

Харин 2020 онд дуусаагүй 2021-2022 онуудад он дамжин хэрэгжиж байгаа дараах төсөл, арга хэмжээ төсөвт өртгөө нэмэгдүүлсэн байна. Тухайлбал:

Их-Уул суманд баригдаж буй Сургуулийн барилга, спорт заалны ажлыг гүйцэтгүүлэхээр Уул-Өвгөд ХХК-тай 3,186.2 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээ байгуулан ажилласан бөгөөд тайлант онд гэрээнд заасан хугацаанд ажлаа бүрэн дуусгалгүйгээр санхүүжилтийг бүрэн авсан бөгөөд 2022 онд гэрээнд сунгалт хийж төсөвт өртгийг 950.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Их-Уул сумын Мандал, Сараалж багийн төвийг эрчим хүчээр холбох ажлыг гүйцэтгүүлэхээр Хас Хан Хөхий ХХК-тай 199.7 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээ байгуулан ажилласан бөгөөд тайлант онд гэрээнд заасан хугацаанд ажлаа бүрэн дуусгалгүйгээр санхүүжилтийг бүрэн авсан бөгөөд 2022 онд гэрээнд сунгалт хийж төсөвт өртгийг 950.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Төрөлх Мөрөн ХХК-ийн гүйцэтгэж буй 144.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй Алаг-Эрдэнэ сумын халуун усны барилгын төсвийг 234.9 сая төгрөг болгон 90.2 сая төгрөгөөр, 148.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй Баянзүрх сумын халуун усны барилгын төсвийг 252.3 сая төгрөг болгон 103.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн “Гранд лайн прожект” ХХК-иар төсөв хийлгэсэн боловч магадлал хийгдээгүй, захиалагч талаас батлагдсан төсвийг нэмэгдүүлэх үндэслэлийг тооцоогүй, хянаагүй байна.

Захиалагч нь Түнэл сумын Засаг даргын тамгын газрын барилгын ажлыг гүйцэтгүүлэхээр Цэгц мандал ХХК-тай 1,197.8 сая төгрөгийн гэрээ байгуулсан бөгөөд гэрээнд заасан хугацаанд ажлаа дуусгаагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон байна. Мөн 2022 онд магадлал хийлгэн төсөвт өртгийн нийт дүнг 1,790.7 сая төгрөг болгон нэмэгдүүлж гэрээг сунгасан байна.

Гэтэл Цагаан-Үүр сумын Засаг даргын тамгын газрын барилгын ажлыг гүйцэтгүүлэхээр Тэмээн ХХК-тай 1,197.8 сая төгрөгийн гэрээ байгуулсан бөгөөд Түнэл сумын Засаг даргын тамгын газрын барилгын ажлыг гүйцэтгэж буй компанитай байгуулсан гэрээний дүн, ажлын тоо хэмжээ ижил байхад төсөвт өртгийг нэмэгдүүлэлгүйгээр гүйцэтгэж байна.

Дээрх тохиолдлоос харахад гүйцэтгэгч компанийн төсөвт өртгийг нэмэгдүүлж буй үйл явц харилцан адилгүй байгааг харуулж байна. Иймд төсөв нэмэгдүүлж буй аж ахуйн нэгжийн зураг төсвийн магадлал, төсөв нэмэгдүүлсэн үндэслэл зэргийг захиалагч талаас хянан, магадлал хийгдээгүй, үндэслэлгүйгээр төсвийг нэмэгдүүлсэн аж ахуйн нэгжтэй холбогдох хууль журамд заасны дагуу хариуцлага тооцож ажиллах шаардлагатай байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний үр нөлөөг тооцохгүйгээс хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт алдагдаж, хэрэгцээ шаардлага ач холбогдол багатай ч төсөвт өртөг ихтэй төсөл, арга хэмжээ хэрэгжсээр байна. Өмнөх онд хэрэгжсэн боловч үр дүнгүй байгаа төсөл, арга хэмжээнээс иш татвал. Жишээ нь:



Жаргалант сумын Соёл спортын цогцолбор нь 3,297.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй баригдсан бөгөөд соёлын төвийн 7 албан хаагч ажилладаг, ашиглалтад орсон цагаас 2 давхрын өрөө, ариун цэвэр, халуун усны өрөөг огт ашиглаагүй, бүрэн хүчин чадлаар ашиглагдаагүй байна. Урсгал үйл ажиллагааны зардлыг тооцоогүйгээс халаалтын өр үүссэн, өрийг төлөх төсөвгүй байна. Барилгыг хүлээлгэж өгсөн цагаас дээврээр ус алдсан боловч одоог хүртэл гүйцэтгэгч компани засварлаагүй байна.



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2015 онд нэг бүр нь 13.2 сая төгрөгийн үнэтэй мал угаалгын ванныг 18 суманд нийлүүлсэн бөгөөд мал угаахад хүндрэлтэй, малчдын хэрэгцээ шаардлагыг хангахгүй ажиллагаа ихтэй тул ашиглалтад авснаас хойш одоог хүртэл зориулалтын дагуу ашиглаагүй, тоног төхөөрөмжийн ашиглалт, хадгалалт хамгаалалт хангалтгүй байна.

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газраас “Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг” гүйцэтгэлийн аудитын тайлангаар 3,135.7 сая төгрөгийн зөрчилд 16 зөвлөмж, 5.8 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт, 1,440.7 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлагыг тус тус хүргүүлсэн байна. Аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Төрийн аудитын газраас Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн, үр нөлөөт байдлыг хангуулах чиглэлээр жил бүр аудит хийн зөвлөмж, албан шаардлага хүргүүлж байгаа ч зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах, алдаа дутагдал давтан гарахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн захиргааны байгууллагууд идэвх санаачилгагүй ажиллаж байгаа нь дээрх зөрчил, дутагдлууд давтагдан гарах үндэслэл болж, улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.

Б.5 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцохгүй байна.

Сангийн яамнаас улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын систем www.publicinvestment.gov.mn веб хуудас болон гар утасны аппликейшн зэргийг нэвтрүүлсэн нь санхүүжилтийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох чиглэлээр арга хэмжээг авч хэрэгжүүлсэн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулах алхам болсон байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт нь нэг талаасаа хувийн секторыг дэмжин, цаашлаад эдийн засаг болоод нийгмийн үзүүлэлтүүд болох ажилгүйдэл буурах, өрхийн орлого нэмэгдэх, ажлын байр бий болох зэрэг эерэг нөлөө үзүүлж, ДНБ-ний өсөлтийг дэмжихэд чиглэгддэг.

Хөвсгөл аймгийн тухайд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эдийн засгийн өсөлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхэд төдийлөн анхаараагүй байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнээс ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр 2021 онд хоёрхон ажил хийгдсэн хэдий ч үр дүнгээ өгөөгүй байна. Тухайлбал:

Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл, Жаргалант, Галт, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Их-Уул, Рашаант сум/-ийн хүрээнд 39.6 сая төгрөгөөр өрхийн амьжиргааг дээшлүүлэх зорилгоор арьс, шир боловсруулах тоног төхөөрөмж бэлтгэсэн боловч одоог хүртэл ашиглагдаагүй, үр дүнгээ өгөөгүй байна.

Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл, Жаргалант, Галт, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Их-Уул, Рашаант сум/-ийн хүрээнд 94 сая төгрөгөөр Оёдлын цехийн тоног төхөөрөмж худалдан авсан боловч 2021 оны 12 дугаар сараас одоог болтол ашиглагдаагүй, ажлын байр болон үр ашгийг нь нэмэгдүүлэх ажил зохион байгуулаагүй байна.

Иймд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг эдийн засаг болон нийгмийн үзүүлэлтүүдэд нөлөөлөхүйц, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлд анхаарч төлөвлөх нь зүйтэй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр нөлөөгөөр нийгмийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн боловсрол, эрүүл мэндийн чиглэлээр нийлүүлсэн техник тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалтууд нь нийгэмд зайлшгүй шаардлагатай үр дүнтэй хөрөнгө оруулалт болсон байна.

Харин эрчим хүчний салбарт 257.2 сая төгрөгийн төсвөөр Төмөрбулаг сумын багийн төвийг эрчим хүчээр хангах, 199.7 сая төгрөгөөр Их-Уул сумын Мандал баг болон Сараалж багийг эрчим хүчээр холбох, 497.6 сая төгрөгөөр Бүрэнтогтох сумын Эрчим, Их-Уул багийг эрчим хүчээр хангах ажлууд тус тус хийгдсэн боловч эрчим хүчний холболт хийгдээгүй, хэрэглэгч багатай үр дүнгээ өгөөгүй байна.

Аудитаар нийт 6,588.4 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 5.5 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 6,358.9 сая төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага, 224.0 сая төгрөгийн зөрчилд 17 зөвлөмжийг тус тус хүргүүлээ.

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжихээр батлагдсан төсөл, арга хэмжээ нь зураг төсөвгүй, техник эдийн засгийн үндэслэлгүй, төсвийн ерөнхийлөн захирагчийн саналд үндэслээгүйгээс харахад Улсын Их Хурлаас төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ баталж эрх шилжүүлсэн байна.
2. Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс нь холбогдох хууль журамд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэхгүй байгаагаас төсөл, арга хэмжээний зураг төсөлд магадлал хийгдээгүй, нэр байршил өөрчилсөн зөрчил гарсан байна.
3. Худалдан авах ажиллагаанд тендерийн баримт бичгийн шалгуур, шаардлагыг хангаагүй гүйцэтгэчийг сонгон шалгаруулсан, зураг төсвийн зөвлөх үйлчилгээ хийлгэх, үнэлгээний хороо байгуулах, тендерт шалгаруулах, гэрээ байгуулах ажиллагаанд хугацаа алдсанаас төсөл, арга хэмжээний хэрэгжилт удааширсан байна.
4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг бодитой хянахгүй байгаагаас хийгдээгүй ажлын гүйцэтгэлд санхүүжилт олгосон, гэрээний хугацаа дууссан байхад гэрээнд өөрчлөлт оруулаагүй, гэрээний хугацаанд сунгалт хийгээгүй, гүйцэтгэгч байгууллагатай алданги тооцоогүй байна.
5. Захиалагч, зураг төсөл зохиогч байгууллагаас барилга угсралтын ажлын явцад хяналт хийх давтамж бага хяналтаар өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг эргэж шалгахгүйгээс зураг, төсөвт тусгагдсан ажил бүрэн хийгдээгүй барилгыг улсын комисс хүлээн авч ашиглалтад оруулсан байна.
6. Орон нутгийн өмчийн газар нь улсын төсвийн хөрөнгө, оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний зарим хөрөнгийг ашиглагч байгууллагад биетээр хүлээлгэж өгөлгүйгээр “Хөрөнгө бүртгэх тухай” тушаал гарган нягтлан бодох бүртгэлд бүртгүүлсэн, орон нутгийн өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалтад тавих хяналт сул байна.
7. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх онуудад хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр ашиг, үр нөлөөг тооцоход аймгийн хэмжээнд хөрөнгө оруулалтын нэгдсэн судалгаа, мэдээллийн сан байхгүйгээс хэрэгцээ шаардлага багатай газар хөрөнгө оруулалтууд хэрэгжүүлсэн, хөрөнгө оруулалтыг нэг газар давхардуулан төлөвлөсөн зэрэг хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцоогүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Г.Мөнгөнхуягт:

1. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгаж хөрөнгийн хадгалалт, хамгаалалт ашиглалтыг сайжруулах.

Аймгийн Засаг дарга Ш.Идэрбаясгаланд:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний хуульд заагдсан нэр, байршил, зориулалт өөрчлөхгүй байх
2. Улсын төсвийн эрх шилжсэн төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолт болон зургийн ажлын даалгаврыг инженер геологийн дүгнэлт, техникийн нөхцөлүүд, газрын зөвшөөрөл, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад үндэслэсэн эсэхийг хянаж батлах
3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах, гэрээний заалтыг биелүүлээгүй аж ахуйн нэгжид гэрээнд заасан хариуцлагын арга хэмжээг авах.
4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж буй байгууллагатай байгуулсан гэрээний үр дүнг тооцож, үнэлэх.
5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцож ажиллах, хөрөнгө оруулалтын ашиглалтыг сайжруулах.
6. “Шинэ хөдөө төсөл”-ийн малын хашаа барих ажлын гүйцэтгэгчээр шалгарч гэрээ байгуулсан “Шидэт гал” ХХК нь гэрээнд заасан ажлаа гүйцэтгээгүй тул хариуцлага тооцож ажиллах.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Ариунбатад:

1. Улсын төсвийн эрх шилжсэн төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолт болон зургийн ажлын даалгаврыг инженер геологийн дүгнэлт, техникийн нөхцөлүүд, газрын зөвшөөрөл, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад үндэслэн эсэхийг хянаж батлах
2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажил гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдийн хариуцлагыг сайжруулж, барилга байгууламжийг дутуу орхих, төсвийн хөрөнгийг үргүйдүүлэх асуудлыг зогсоох шаардлагатай байгаа тул төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн үр дүнгээр хариуцлага хүлээлгэж байх
3. Төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолт болон зургийн ажлын даалгаврыг инженер геологийн дүгнэлт, техникийн нөхцөлүүд, газрын зөвшөөрөл, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад үндэслэн боловсруулах

Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Должинсоргодогт:

1. Улсын төсвийн хөрөнгө, оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хөрөнгийн бүртгэл, тайлагнал, ашиглалт, хадгалалтад тавих хяналтыг сайжруулах.
2. Үнэлгээний хороо байгуулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах ажиллагаанд үүсч байгаа хугацааны алдагдлыг арилгаж, худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулах
3. Худалдан авах ажиллагааны тайланг үнэн зөв тайлагнах

Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга Б.Ганзоригт:

1. Барилга, байгууламжийн зураг төсөлд магадлал хийх ажлыг хууль, дүрэмд заасны дагуу зохион байгуулах

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Оюунтуяад:

1. Төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолт болон зургийн ажлын даалгаврыг инженер геологийн дүгнэлт, техникийн нөхцөлүүд, газрын зөвшөөрөл, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад үндэслэн боловсруулах
2. Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт үр дүнг хариуцах хууль, журамд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж, улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний батлагдсан нэр, байршил, хүчин чадал, тоо хэмжээг өөрчлөхгүй байх.
3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах, гэрээний заалтыг биелүүлээгүй аж ахуйн нэгжид гэрээнд заасан хариуцлагын арга хэмжээг авах.
4. Боловсролын соёлыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Тариалан сумын Хүүхдийн цэцэрлэгт нийлүүлэгдсэн ажиллахгүй байгаа 1.9 сая төгрөгийн 1 ширхэг суурин компьютерыг гэрээний үүргийн дагуу гүйцэтгэгчээр солиулах.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн дараах төсөл, арга хэмжээ хэрэгцээ шаардлагагүй, үр ашиггүй хөрөнгө оруулалт болж байгаа тул харьяалах яаманд хандан холбогдох арга хэмжээ авч эргэж хариу мэдэгдэх шаардлагатай байна.

- БХБС-ын багц:** Улсын төсвийн хөрөнгөөр 2021-2022 онд хэрэгжих 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Гэр хорооллын хөрсний бохирдлыг багасгах эко ариун цэврийн байгууламж /Хөвсгөл, Мөрөн сум/. Тус төсөл арга хэмжээгээр 120 айлын хашаанд эко 00 барихаар төсөвлөгдөн хэрэгжиж байгаа нь улсын төсвийн хөрөнгийн өмчлөл, бүртгэл хөтлөлтийг зөрчиж байгаагаас гадна үр дүн, үр ашгийг бууруулж байна.
- ХНХС-ын багц:** Шинэ-Идэр сум нь хуучин ахмадын өргөөний барилгатай бөгөөд 2021 оны улсын төсвийн эрх шилжсэн хөрөнгө оруулалтаар 77.2 сая төгрөгийн ахмадын өргөө шинээр баригдсан бөгөөд 2022 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дахин 250.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Ахмадын төвийн барилга баригдаж байна. Аудитаар тус суманд 2022 онд дахин ахмадын өргөө барих нь хэрэгцээ шаардлагагүй хөрөнгө оруулалт гэж үзлээ.
- Аж ахуйн нэгжийн барьсан стандартын шаардлага хангахгүй барилгыг Улсын төсвийн хөрөнгөөр худалдан авч тухайн төсөл, арга хэмжээнд зориулан тендерийг зохион байгуулж байгаа нь хөрөнгө оруулалтын чанар, хэрэгцээ шаардлага, үр дүн, үр ашигт нөлөөлөхөөс гадна худалдан авах ажиллагаанаас зайлсхийж хуулийн этгээдэд давуу байдал үүсгэсэн шинжтэй байна. Цаашид стандартын шаардлагад нийцээгүй баригдсан барилга, байгууламжийг улсын төсвийн хөрөнгөөр худалдан авахгүй байхыг эрх бүхий газарт уламжлах.

Хөвсгөл аймгийн хэмжээнд Улсын төсвийн хөрөнгөөр дараах барилгуудыг аж ахуйн нэгжээс худалдан авч орон нутгийн өмчид бүртгэсэн байна. Үүнд:

№	Төсөл арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг /сая.төг/	Нийлүүлсэн компани
1	Ахмадын чийрэгжүүлэлтийн төвийн барилга худалдан авах /Хөвсгөл Мөрөн сум/	2020-2021	250.0	Гүрт хязгаар ХХК
2	Цэцэрлэгийн барилга худалдан авах /Хөвсгөл, Жаргалант сум/	2020-2021	450.0	Дээд хонх ХХК
3	Спортын заалны барилга худалдан авах /Хөвсгөл, жаргалант сум/	2020-2021	200.0	Денсфорист ХХК
4	Сургуулийн дотуур байрын өргөтгөлийн барилга худалдан авах /Хөвсгөл, Галт сум, Зүрх баг/	2020-2021	850.0	Мөрөн Чандмань Эрдэнэ ХХК
5	Хавдрын эрт илрүүлгийн төвийн барилга худалдан авах /Хөвсгөл, Мөрөн сум/ ажлын санхүүжилт	2021-2021	1,400.0	БЭНҮҮ ОНОШ ХХ
НИЙТ ДҮН			3,150.0	

Зөрчлийн жагсаалт:

/Сая.төгрөг/

№	Илэрсэн зөрчлийн		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Утга	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Зарим төсөл арга хэмжээний зургийн ажлын даалгаврыг инженер геологийн дүгнэлт, техникийн нөхцөлүүд, газрын зөвшөөрөлд үндэслэн боловсруулаагүй байна.						4	
2	Шинээр баригдах барилга байгууламжийн зураг төсвийн 70 хувийг магадлалаар баталгаажуулаагүй байна.						2	
3	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг багц болгон хувааж, техникийн тодорхойлолтыг боловсруулахдаа нэр, байршлыг өөрчлөн төсөл, арга хэмжээг хуульд заасан сумдад хэрэгжүүлэлгүй өөр сумдад хэрэгжүүлсэн, хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл, арга, хэмжээг хэрэгжүүлсэн, техникийн үзүүлэлтийг хангалтгүй боловсруулсан, үр ашиг бууруулсан байна.						1	
4	Үнэлгээний хороо байгуулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах ажиллагаанд хугацаа алдсанаас төсөл, арга хэмжээний хэрэгжилт удааширсан байна.						1	
5	Худалдан авах ажиллагаанд тендерийн баримт бичгийн шалгуур, шаардлагыг хангаагүй болон боловсон хүчин, техникийн чадавх, хэрэгжүүлж буй ажлын байдлыг бүрэн үнэлэлгүй хэд хэдэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр нэг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан, худалдан авах ажиллагааны хууль, журмыг бүрэн мөрдөхгүй байгаа зэрэг зөрчилтэй зүйлс илэрч байгаа тул худалдан авах ажиллагааны хууль журмыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.	720.0			1	720.0		
6	Худалдан авах ажиллагааны тайланг 31.1 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.	31.1					1	31.1
7	Захиалагч нь гүйцэтгэгч байгууллагын гэрээний хугацаа дууссан байхад гэрээнд өөрчлөлт оруулаагүй, алданги тооцоогүй, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын гэрээг үнэлж, дүгнээгүй байна.	5.5	1	5.5				
8	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн хөрөнгө оруулалтыг бүрэн ашиглахгүй, хөрөнгө оруулалтын үр дүн, үр ашгийг гаргахгүй байна.						3	
9	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл, Жаргалант, Галт, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Их-Уул, Рашаант сум/ IV.1.29/ багц-8-ийн хүрээнд тус бүр нь 3.3 сая төгрөгийн үнэ бүхийн 25 ширхэг нийт 82.0 сая төгрөгийн Мустанг-5 мотоцикл худалдан авч сумдын багийн эмч болон багийн дарга нарт зах зээлийн үнээс хэт өндөр дүнтэй нийлүүлсэн.	12.5			1	12.5		
10	Захиалагч, зураг төсөл зохиогч байгууллагаас барилга угсралтын ажлын явцад хяналт хийх давтамж бага хяналтаар өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг эргэж шалгахгүйгээс зураг, төсөвт тусгагдсан ажил бүрэн хийгдээгүй	4,431.3			1	4,431.3		

	барилгыг улсын комисс хүлээн авч ашиглалтад оруулсан байна.							
11	Захиалагчийн хяналтын зардлаас хяналтыг хэрэгжүүлэхээс гадна ОНӨГ-ын гэрээт албан хаагчын цалинд 7.0 сая төгрөг, бичиг хэргийн зардалд 8.9 сая төгрөгийг, ГХБХБГ-т 28.7 сая төгрөгийг тус тус шилжүүлж барилга байгууламжийн захиалагчийн хяналтын зардлаас санхүүжүүлэх зардлын нэр төрөлд хамаарахгүй зардалд зарцуулсан байна.	16.9			1	16.9		
12	Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжсэн зарим төсөл арга хэмжээний гүйцэтгэл дутуу, зураг төсөвт тусгагдсан ажил бүрэн хийгдээгүй, ажлын үе шатны гүйцэтгэл бодит бус байхад санхүүжилтийг бүрэн олгосон байна.	1,108.1			1	1,108.1		
13	Аймгийн ОНӨГ нь улсын төсвийн хөрөнгө, оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний зарим эд хөрөнгийг ашиглагч байгууллагад биетээр хүлээлгэж өгөлгүйгээр “Хөрөнгө бүртгэх тухай” тушаал гарган нягтлан бодох бүртгэлд бүртгүүлсэн, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтад тавих хяналт сул байна	191.0					3	191.0
14	Боловсролын соёлыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Тариалан сумын Хүүхдийн цэцэрлэгт нийлүүлэгдсэн ажиллахгүй байгаа 1.9 сая төгрөгийн 1 ширхэг суурин компьютерыг гэрээний үүргийн дагуу гүйцэтгэгчээр солиулах.	1.9					1	1.9
15	“Шинэ хөдөө төсөл”-ийн малын хашаа барих ажлын гүйцэтгэгчээр шалгарч гэрээ байгуулсан “Шидэт гал” ХХК нь гэрээнд заасан ажлаа гүйцэтгээгүй, хариуцлага тооцож ажиллах.						1	
16	Шинэ хөдөө төсөл хөтөлбөрийн хүрээнд “Махны чиглэлийн Сэлэнгэ үүлдрийн тугалтай 80 үнээ, 4 бух” нийлүүлэхээр Баяншувуут ХХК-тай 223.2 сая төгрөгийн гэрээ байгуулан барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлсэн боловч малын арчилгаа, хариулга, хашаа хороо бэлэн бус байснаас хорогдол гарсан байна.	70.1			1	70.1		
НИИТ ДҮН		6,588.4	1	5.5	7	6,358.9	17	224.0

Байгууллагын саналууд:

1. Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газар:

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР		ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ
АЗДТГ-ын байр А корпус 1 давхар 8 дугаар баг, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120 Утас: 7038 8849, 7038 8821, факс: 7038 8848 Цахим шуудан: khuvsgul-tander@khs.gov.mn Цахим хуудас: http://umch.khs.gov.mn		
2022.05.02 № 1/348		
төний	ны №	-т
Хариу хүргүүлэх тухай		
Хөвсгөл аймгийн Аудитын газрын ХӨА-2022/16-21-ШТА-ГА дугаар аудитын зөрчлийн бүртгэлийн дагуу хариуг хүргүүлж байна. “Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд нийлүүлэгдсэн 25 ширхэг мотоциклыг Орон нутгийн өмчийн газрын даргын 1/121 тушаалаар эзэмшүүлэх тушаал гаргасан боловч эзэмшигчид хүлээлгэн өгөөгүй зөрчил байна” гэсэн нь хөрөнгө эзэмшигч байгууллагын дарга эрхлэгч нар 2021 оны 12 дугаар сард өөрсдийн биеэр хүлээн авсан бөгөөд Улсын дугаар гэрчилгээг өөрсдийн байгууллагын нэр дээр гаргах хүсэлтийг өгч бүртгэл бүрэн хийгдсэн. Ковид-19 цар тахлын улмаас хойшлогдсон багийн иргэдийн Нийтийн хурал хуралдаж шинээр томилогдох Багийн Засаг дарга нарт шууд хүлээлгэн өгөх, тэсгэм цагт мотоциклын хөдөлгөөн хориглох шийдвэрийн дагуу хөдөлгөөн нээгдэх хүртэлх хугацаанд аймгийн Засаг даргын Тамгын газрын агуулахад хадгалуулахыг зөвшөөрсөн болно. Иймд албан шаардлагаас хасч холбогдох байгууллага албан тушаалтанд зөвлөмж болгож өгнө үү. Мотоциклын зах зээлийн үнэлгээг тээврийн хэрэгслийн гаалийн бүрдүүлэлт бүрэн тээврийн хэрэгслийн нэрээр орж ирсэн мотоцикл, сэлбэгээр гаалийн бүрдүүлэлт хийсэн мотоциклын үнээс өндөр байгаа нь цаашид улсын дугаар гэрчилгээгүй тээврийн хэрэгслийг үгүй болгох шийдэл юм. Иймд төлбөрийн актаас хасч өгнө үү. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын орон тоон дээр захиалагчийн хяналт хариуцан ажиллаж байсан мэргэжилтэн нь 2022 оны 3 сард ажлаас гарах хүсэлт гаргасны дагуу түүнийг ажлаас 2022 оны 3 дугаар сарын 14-ний өдрөөс тасалбар болгон чөлөөлсөн ба уг ажлын байранд хүн авч ажиллуулаагүй байна. Тиймээс захиалагчийн хяналт хариуцсан ажилтанг ажиллуулахгүй байх албан шаардлагыг хасч өгнө үү. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 53.2 дахь хэсэгт зааснаар аймгийн орон нутгийн өмчийн газар нь худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх чиг үүрэгтэй бөгөөд аймгийн Засаг даргын Тамгын газрын 2018 оны А/68 дугаар тушаалаар ТОНӨХБАҮХАТ хуулийн 46 дугаар зүйлд заасан захиалагчийн эрхийг аймгийн Орон нутгийн өмчийн газарт шилжүүлсэн тул тус газрын албан хаагчид нь захиалагчийн хувьд Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан журмын 3.1.3, 3.1.4, 3.4 дэх хэсэгт заасан бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээг боловсруулан хэвлэх, байгуулах, тус гэрээг дүгнэх, захиалагчийн болон зохиогчийн хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллагуудтай зохиогчийн хяналт хэрэгжүүлэх гэрээг байгуулах, дүгнэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг болно. Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 85 дугаар тушаал болон аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 57 дугаар тогтоолоор баталсан журмын 3.16 дахь заалтыг үндэслэн тус газрын 12 албан хаагчдад 8,226.5 мянган төгрөгийн бичиг хэргийн болон бусад бараа материал худалдан авсан нь холбогдох хууль тогтоомжийг зөрчөөгүй болно. Иймд зөрчлөөс хасч өгнө үү! Улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлэх талаар Орон нутгийн өмчийн газраас өмч эзэмших байгууллагын дарга эрхлэгч нартай аймгийн Засаг даргын 2018 оны А/82 дугаар захирамжаар баталсан “Орон нутгийн өмчит байгууллагын өмч эзэмшлийн гэрээ” байгуулж байгууллагын дарга эрхлэгч нар ажилтнуудтайгаа “Өмчийн		

d/A4

6712020207

бүрэн хариуцлагын гэрээ” байгуулан ажиллаж байгаа тул өмчийн эзэмшил ашиглалт, хадгалалт хамгаалалт дээр хариуцлага алдсан байгууллагын нэрээр ирүүлнэ үү. Бид байгууллага албан тушаалтанд хариуцлага тооцох асуудлыг шат шатанд нь шийдвэрлэн ажиллах болно.

Шинэ хөдөө төслийн үхэр сүргийн хариулга маллагааг хариуцан ажиллах иргэнийг Тариалан сумаас сонгон тэрхүү малчинтай аймгийн Хүнс Хөдөө аж ахуйн газар, Орон нутгийн өмчийн газраас гэрээ байгуулан ажилласан.

Дээрх асуудлын бүртгэлд дурдагдсан 22 үнээ дутагдсаны 14 үнээ хорогдсон нь сэг зэм, баталгаажих тэмдэгээр баталгаажсан. 8 үнээ тодорхой бус байна. 45 бяруунаас 17 бярууг малчдад онд оруулах гэрээгээр өгсөн өөр суурьт хариулагдаж байгаа. 28 бяруу дутагдсанаас 22 бярууг нотлох баримтаар баталгаажуулсан. 6 бяруу тодорхойгүй байна. 1 бүх тариан талбайд орж будааны хог идэж үхсэн малчин өөрөө хариуцлага алдсан төлнө гэж хүсэлт бичиж өгсөн.

Аймгийн Хүнс Хөдөө аж ахуйн газар, Орон нутгийн өмчийн газраас Д.Дамдиндоржтой байгуулсан гэрээг 2022 оны 03-р сарын 30-ны өдөр дүгнэж хорогдуулсан, дутагдуулсан малын үзлэг тооллогыг зохион байгуулж холбогдох байгууллагад шилжүүлэхээр ажиллаж байна. Иймд асуудлыг шуурхай шийдвэрлэж холбогдох этгээдэд хариуцлага тооцох албан шаардлага болгож өгнө үү.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Б.ДОЛЖИНСОРОГДОГ

Орон нутгийн өмчийн газрын саналыг шийдвэрлэсэн байдал

Аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2022 оны 1/348 дугаар бичгийн хавсралт.

“УЛСЫН ТӨСВИЙН 2021 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛД ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРААС ХҮРГҮҮЛЭХ САНАЛ

(Сая төгрөг)

№	Зөрчлийн жагсаалт	Орон нутгийн өмчийн газрын тайлбар	Саналд өгөх тайлбар
1	ОНӨГ-аас тайланд онд 16 мотоциклийг сумдад хүлээлгэж өгөлгүйгээр хөрөнгөд бүртгүүлсэн ч 5 сарын турш шаардлагатай албан хаагчдад хүргэгдээгүй байгаа нь төсөл, арга хэмжээний үр дүн, үр ашиг, хэрэгцээ шаардлагыг бууруулж байна.	“Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд нийлүүлэгдсэн 25 ширхэг мотоциклийг Орон нутгийн өмчийн газрын даргын 1/121 дугаар тушаалаар эзэмшүүлэх тушаал гаргасан боловч эзэмшигчид хүлээлгэн өгөөгүй зөрчил байна.” гэсэн нь хөрөнгө эзэмшигч байгууллагын дарга эрхлэгч нар 2021 оны 12 дугаар сард өөрсдийн биеэр хүлээн авсан бөгөөд улсын дугаар, гэрчилгээг өөрсдийн байгууллагын нэр дээр гаргах хүсэлтийг өгч бүртгэл хийгдсэн. Ковид-19 цар тахлын улмаас хойшлогдсон багийн иргэдийн Нийтийн хурал хуралдаж шинээр томилогдох багийн Засаг дарга нарт шууд хүлээлгэн өгөх, тэсгэм цагт мотоциклын хөдөлгөөн хориглох шийдвэрийн дагуу хөдөлгөөн нээгдэх хүртэл хугацаанд аймгийн ЗДТГ-ын агуулахад хадгалуулахыг зөвшөөрсөн болно. Иймд албан шаардлагаас хасч холбогдох албан тушаалтанд зөвлөмж болгож өгнө үү.	Саналыг хүлээн авч зөвлөмж болгосон.
2	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл, Жаргалант, Галт, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Их-Уул, Рашаант сум/ IV.1.29/ багц-8-ийн хүрээнд тус бүр нь 3.3 сая төгрөгийн үнэ бүхийн 25 ширхэг нийт 82.0 сая төгрөгийн Мустанг-5 мотоцикл худалдан авч сумдын багийн эмч болон багийн дарга нарт нийлүүлсэн байна. Тус мотоциклуудыг нийлүүлсэн Төрөлх Мөрөн ХХК нь нэг бүрийг зах зээлийн үнэлгээнээс ойролцоогоор 0.5 сая төгрөгөөр нийт 12.5 сая төгрөгөөр илүү дүнтэйгээр гэрээ байгуулсан бөгөөд хүчин чадлын хувьд үзүүлэлт муутай байна.	Мотоциклын зах зээлийн үнэлгээг тээврийн хэрэгслийн гаалийн бүрдүүлэлт бүрэн тээврийн хэрэгслийн нэрээр орж ирсэн мотоцикл, сэлбэгээр гаалийн бүрдүүлэлт хийсэн тээврийн мотоциклын үнээс өндөр байгаа нь цаашид улсын дугаар гэрчилгээгүй тээврийн хэрэгслийг үгүй болгох шийдэл юм. Иймд төлбөрийн актаас хасч өгнө үү.	Саналыг хүлээн авч Хөрөнгө, оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолт боловсруулахад анхаарах зөвлөмж болгон өөрчлөв.
3	Захиалагчийн хяналтын зардлаас хяналтыг хэрэгжүүлэхээс гадна ОНӨГ-ын гэрээт албан хаагчийн цалинд 7.0 сая төгрөг, бичиг хэргийн зардалд 8.9 сая төгрөгийг, ГХБХБГ-т 28.7 сая төгрөгийг тус тус шилжүүлж барилга байгууламжийн захиалагчийн хяналтын зардлаас санхүүжүүлэх зардлын нэр төрөлд хамаарахгүй зардалд зарцуулсан байна.	Аймгийн Орон нутгийн өмчийн газрын орон тоон дээр захиалагчийн хяналт хариуцан ажиллаж байсан мэргэжилтэн нь 2022 оны 03 дугаар сараас ажлаас гарах хүсэлт гаргасны дагуу түүнийг ажлаас 2022 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөр тасалбар болгон чөлөөлсөн ба уг ажлын байранд хүн авч ажиллуулаагүй байна. Тиймээс захиалагчийн хяналт хариуцсан ажилтан ажиллуулахгүй байх албан шаардлагыг хасаж өгнө үү. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.2 дахь хэсэгт заанаар аймгийн Орон нутгийн өмчийн газар нь худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх чиг үүрэгтэй бөгөөд хуулийн 46 дугаар зүйлд заасан захиалагчийн эрхийг аймгийн Орон нутгийн өмчийн газарт шилжүүлсэн тул тус газрын албан хаагчид нь захиалагчийн хувьд Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан журмын 3.1.3, 3.1.4, 3.4 дэх хэсэгт заасан бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээг боловсруулан хэвлэх, байгуулах, дүгнэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг болно. Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 85 дугаар тушаал болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 58 дугаар тогтоолоор баталсан журмын 3.16 дахь заалтыг үндэслэн тус газрын 12 албан хаагчдад 8,226.5 мянган төгрөгийн бичиг хэргийн болон бусад бараа материал худалдан авсан нь холбогдох хууль, журмыг зөрчөөгүй болно. Иймд зөрчлөөс хасаж өгнө үү.	Тайлбарыг хүлээн авах боломжгүй. Тайлбарт дурдсан зүйлс захиалагчийн хяналтад хамааралтай гэж үзэх боломжгүй байна.

4	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутагт бий болсон хөрөнгөд ОНӨГ-аас тавих хяналт сул байгаагаас зарим хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт алдагдаж, үр ашиг буурч байна.	Улс, орон төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлэх талаар Орон нутгийн өмчийн газраас өмч эзэмших байгууллагын дарга, эрхлэгч нартай аймгийн Засаг даргын 2018 оны А/82 дугаар захирамжаар баталсан “Орон нутгийн өмчит байгууллагын өмч эзэмшлийн гэрээ” байгуулж байгууллагын дарга, эрхлэгч нар ажилтнуудтайгаа “Өмчийн бүрэн хариуцлагын гэрээ” байгуулан ажиллаж байгаа тул өмчийн эзэмшилт хамгаалалт дээр хариуцлага алдсан байгууллагыг нэрээр ирүүлнэ үү. Бид байгууллага албан тушаалтанд хариуцлагаа тооцох асуудлыг шат шатанд нь шийдвэрлэн ажиллах болно. Шинэ хөдөө төслийн үхэр сүргийн хариулга маллагааг хариуцан ажиллах иргэнийг Тариалан сумаас сонгон тэрхүү малчинтай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Орон нутгийн өмчийн газраас гэрээ байгуулан ажилласан. Дээрх асуудлын бүртгэлд тусгагдсан 22 үнээ дутагдсаны 14 үнээ хорогдсон нь сэг зэм, баталгаажих тэмдгээр баталгаажсан 8 үнээ тодорхой бус байна. 45 бяруунаас 17 бярууг малчдад оруулах гэрээгээр өгсөн өөр суурьт хариуцлагдаж байгаа. 28 бяруу дутагдсанаас 22 бярууг нотлох баримтаар баталгаажуулсан. 6 бяруу тодорхойгүй байна. 1 бух тариан талбайд орж будааны хог идэж үхсэн малчин өөрөө хариуцлага алдсан төлнө гэж хүсэлт бичиж өгсөн. Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Орон нутгийн өмчийн газраас Д.Дамдиндоржтой байгуулсан гэрээг 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдөр дүгнэж хорогдуулсан, дутагдуулсан малын үзлэг тооллогыг зохион байгуулж холбогдох байгууллагад шилжүүлэхээр ажиллаж байна. Иймд асуудлыг шуурхай шийдвэрлэж холбогдох этгээдэд хариуцлага тооцох албан шаардлага болгож өгнө үү.	Аудитаар санал гаргасан байгууллагын үйл ажиллагаа хангалтгүй байсан тул саналыг хүлээн авах боломжгүй байна. Саналыг хүлээн авч хариуцсан албан хаагчдад хариуцлага тооцуулах санал хүргүүлэхээр шийдвэрлэв.
---	--	---	---

ТАЙЛБАР БИЧСЭН: ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ДОЛЖИНСОРОГДОГ

2. Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар:


ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР
 7 дугаар баг, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120.
 Утас, факс: 70352929
 Цахим шуудан: gathbgazar@khs.gov.mn
 Цахим хуудас: www.khovsgol.gazar.gov.mn
 2022.05.04 № 4/297
 танай _____ -ны № _____ -т

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Танай газрын 2022 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 01/346 тоот албан бичгээр “Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-нд гүйцэтгэлийн аудит хийсэн тухай ХӨА-2022/16-21-ШТА-ГА кодтой тайланг ирүүлсний дагуу тайлантай танилцлаа.

Тайлангийн төсөлтэй санал нэг байгаа тул цаашид хэрэгжилтийг хангаж ажиллах болно.

Холбогдох заалтын тайлбарыг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт хуудас.

ДАРГА  Б.ГАНЗОРИГ

3. Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс:



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120,
Утас: 7038 3303, Цахим шуудан: huvsgulzdtg@khs.gov.mn
Цахим хуудас: www.khovsgol.gov.mn

№ 6950

тантай _____ ны № _____

Санал хүргүүлэх тухай

“Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд санал хүргүүлэв.
Хавсралт хуудастай.

**ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ**


Б.ОЮУНТУЯА

My Door jikg toot

**“УЛСЫН ТӨСВИЙН 2021 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН
ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛД САНАЛ ХҮРГҮҮЛЭХ**

№	Илэрсэн зөрчлийн	
	Утга	
3	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг багц болгон хувааж, техникийн тодорхойлолтыг боловсруулахдаа нэр, байршлыг өөрчлөн төсөл, арга хэмжээг хуульд заасан сумдад хэрэгжүүлэлгүй өөр сумдад хэрэгжүүлсэн, хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл, арга, хэмжээг хэрэгжүүлсэн, техникийн үзүүлэлтийг хангалтгүй боловсруулсан, үр ашиг бууруулсан байна.	Улсын Их Хурлын Л.Энх-амгалан гишүүнээс Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг багц болгон хувааж, техникийн тодорхойлолтыг боловсруулахдаа нэр, байршлыг өөрчлөн төсөл, арга хэмжээг хуульд заасан сумдад хэрэгжүүлэлгүй өөр сумдад, хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл, арга, хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөлтийг ирүүлсэний дагуу 12 багц арга хэмжээ болгон задалж хэрэгжүүлсэн. Үүнийг хасуулах саналтай байна.
4	Захиалагч нь гүйцэтгэгч байгууллагын гэрээний хугацаа дууссан байхад гэрээнд өөрчлөлт оруулаагүй, алданги тооцоогүй, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын гэрээг үнэлж, дүгнээгүй байна.	Гүйцэтгэгч байгууллагын буруутай үйл ажиллагаанаас шалтгаалаагүй бөгөөд Улсын комисс оройтож ажилласан нь гүйцэтгэгч байгууллагын буруутай үйл ажиллагаа биш бөгөөд Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл, Жаргалант, Галт, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Их-Уул, Рашаант сум/ IV.1.29/ багц-1 ажлын гүйцэтгэгч Хөгийн чулуу ХХК, Сургуулийн дотуур байрын өргөтгөлийн барилга худалдан авах /Хөвсгөл, Галт сум, Зүрх баг/ ажлын гүйцэтгэгч Мөрөн Чандмань Эрдэнэ ХХК, Багийн сэргээгдэх эрчим хүчний холболт /Хөвсгөл, Төмөрбулаг сум/ ажлын гүйцэтгэгч Эрчим elektrik ХХК, Цэцэрлэгийн барилгын их засвар, Сургуулийн барилгын их засварын /Хөвсгөл, Ханх сум/ ажлын гүйцэтгэгч Этүгэн жим ХХК, Ахмадын өргөөний барилга /Хөвсгөл, Шинэ-Идэр сум/ ажлын гүйцэтгэгч Хөвсгөл Хүрмэн ХХК, Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл, Жаргалант, Галт, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Их-Уул, Рашаант сум/ IV.1.29/ багц-3 /Өл тоом/ Багц-3 ажлын гүйцэтгэгч Эрдэнийн харгуй ХХК, Багц-4, Багц-6 ажлын гүйцэтгэгч Төрөлх мөрөн ХХК нарт алданги тооцох санал дээр санал нийлэхгүй байгаа тул хасуулах саналтай байна. Холбогдох баримтыг хавсралтаар хүргүүлэв.
5	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл, Жаргалант, Галт, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Их-Уул, Рашаант сум/ IV.1.29/ багц-8-ийн хүрээнд тус бүр нь 3.3 сая төгрөгийн үнэ бүхийн 25 ширхэг нийт 82.0 сая төгрөгийн Мустанг-5 мотоцикл худалдан авч сумдын багийн эмч болон багийн дарга нарт зах зээлийн үнээс хэт өндөр дүнтэй нийлүүлсэн.	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл, Жаргалант, Галт, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Их-Уул, Рашаант сум/ IV.1.29/ багц-8-ийн хүрээнд МУСТАНГ 5 мотоцикл нийлүүлсэн Төрөлх мөрөн ХХК-нийг мотоцикл нийлүүлэхэд ковид-19 цар тахлаас шалтгаалан хил хаагдсантай холбогдуулан үнийн хөөрөгдөл өндөр байсан нь одоогийн зах зээлийн үнээс өндөр байгаа тул хасуулах саналтай байна.
6	Өмнөх онд хэрэгжсэн Ханх сумын сургуулийн 1-р байрны засварын ажлын гүйцэтгэлтэй холбоотой аудитаар албан шаардлага хүргүүлсэн боловч тухайн ажил хийгдээгүй байхад 13.5 сая төгрөгийн барьцаа хөрөнгийг чөлөөлсөн байна.	Ханх сумын сургуулийн 1-р байрны засварын ажлын гүйцэтгэгч Икосаэдр ХХК нь засварын дутуу ажлаа хийсэнг Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан ажлын хэсгийн хурлын тэмдэглэл гарч барьцаа хөрөнгийг чөлөөлсөн бөгөөд гүйцэтгэгч байгууллага 2020 онд Улсын комиссын өгсөн үүрэг даалгавар зураг төсөвт тусгаагдаагүй ажлын тоо хэмжээнээс гадуур Мөн улсын комиссын ажлын үүрэг даалгаварт бүр тусгаагдаагүй, хэрэглэгчийн хүсэлтийн дагуу нэмэлт ажлуудыг өөрийн нэмэлт

		хөрөнгөөр засварын ажлыг хийж дуусгасан бөгөөд энэхүү ажлуудын төсөвт өртөг нь барьцаа хөрөнгийн дансанд байршиж байсан санхүүжилтээс илүү гарсан тул ажлын хэсгийн хурлын тэмдэглэлээр баталгаажиж чанарын барьцааг чөлөөлсөн тул акт тавиулахгүй хасуулах саналтай байна. Холбогдох баримтыг хүргүүлэв.
7	Боловсролын соёлыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Тариалан сумын Хүүхдийн цэцэрлэгт нийлүүлэгдсэн ажиллахгүй байгаа 1.9 сая төгрөгийн 1 ширхэг суурин компьютерыг гэрээний үүргийн дагуу гүйцэтгэгчээр солиулах.	Боловсролын соёлыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд тоног төхөөрөмж нийлүүлсэн Саммит компьютер технологи ХХК нь энэхүү тоног төхөөрөмжийн задрэлийг баталгаат хугацааны хүрээнд засвар үйлчилгээг хийнэ. Харин ашиглалтын буруутай үйл ажиллагаанаас шалтгаалсан эвдрэл гэмтэл бол бид хариуцах боломжгүй гэсэн мэдэгдэл хийсэн тул гүйцэтгэгч байгууллагын хамт сонсох ажиллагаа хийх саналтай байна.

ТАЙЛБАР

ХЯНАСАН: ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ,
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ОЮУНТУЯА

БИЧСЭН: ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ,
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Л.ЗАНДАНМЯДАГСҮРЭН

Саналд өгөх хариу тайлбар

"УЛСЫН ТӨСВИЙН 2021 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ" ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛД ХБТХО-ЫН ХЭЛТСЭЭС ИРҮҮЛСЭН САНАЛ

(Сая төгрөг)

№	Зөрчлийн жагсаалт	Орон нутгийн өмчийн газрын тайлбар	Саналд өгөх тайлбар
1	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг багц болгон хувааж, техникийн тодорхойлолтыг боловсруулахдаа нэр байршлыг өөрчлөн, төсөл, арга хэмжээг хуульд заасан сумдад хэрэгжүүлэлгүй өөр сумдад хэрэгжүүлсэн, хөрөнгө оруулалтын бус шинж бус төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн, техникийн үзүүлэлтийг хангалтгүй боловсруулсан үр ашиг бууруулсан байна.	УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалангаас Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг багц болгон хувааж, техникийн тодорхойлолтыг боловсруулахдаа нэр, байршлыг өөрчлөн төсөл, арга хэмжээг хуульд заасан сумдад хэрэгжүүлэлгүй өөр сумдад, хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөлтийг ирүүлсний дагуу 12 багц арга хэмжээ болгон задалж хэрэгжүүлсэн. Үүнийг хасуулах саналтай байна.	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс нь хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүнг хариуцах тул саналыг хүлээн авах боломжгүй байна.
2	Захиалагч нь гүйцэтгэгч байгууллагын гэрээний хугацаа дууссан байхад гэрээнд өөрчлөлт оруулаагүй, алданги тооцоогүй, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын гэрээг үнэлж, дүгнээгүй байна.	Улсын комисс оройтож ажилласан нь гүйцэтгэгч байгууллагын буруу биш тул алданги тооцох төлбөрийн акттай санал нийлэхгүй, хасуулах саналтай байна. Холбогдох баримтыг хавсралтаар хүргүүлэв.	Ирүүлсэн баримтад үндэслэн зарим төсөл, арга хэмжээний алдангийн дүнг хассан. Харин нотлох баримтгүй алдангийг хэвээр тооцож акт тогтоов.
3	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн багц 8 багийн Засаг дарга, эмч нарыг унаажуулах төсөл, арга хэмжээний зах зээлийн үнээс өндөр үнээр тогтоосон	Ковид-19 цар тахлаас шалтгаалан хил хаасантай холбогдуулан, үнийн хөөргөдөл өндөр байсан нь одоогийн зах зээлийн үнээс өндөр байгаа тул хасуулах саналтай байна.	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс нь хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүнг хариуцах тул саналыг хүлээн авах боломжгүй байна.
4	Өмнөх онд хэрэгжсэн Ханх сумын сургуулийн засварын ажлын гүйцэтгэлтэй холбоотой аудитаар албан шаардлага хүргүүлсэн боловч тухайн ажил хийгдээгүй 13.5 сая төгрөгийн барьцааг сулласан байна.	Ханх сумын сургуулийн 1-р барын засварын ажлыг гүйцэтгэгч “Икосаэдр” ХХК нь засварын хангалтгүй ажлуудыг сайжруулан хийж мөн ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгавар, зураг төсөвт тусгагдаагүй нэмэлт ажлуудыг хэрэглэгч байгууллагын саналаар зарим ажлуудыг өөрийн хөрөнгөөр хийсэн байна. Өөрийн хөрөнгөөр хийсэн ажил нь барьцаа хөрөнгөнөөс илүү гарсан тул барьцааг сулласан. Иймд акт тавиулахгүй байх саналтай байна.	Гүйцэтгэгч байгууллагатай уулзалт хийж ажлын тайлан, гаргасан хөрөнгөд баримтын хяналт хийсний үндсэн дээр саналыг хүлээн авав.
4	Боловсрол, соёлыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Тариалан сумын Хүүхдийн цэцэрлэгт 1.9 сая төгрөгийн ажилладаггүй суурин компьютер нь нийлүүлэгдсэн байна.	Боловсрол соёлыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд тоног төхөөрөмж нийлүүлсэн “Саммит компьютер технологи”ХХК нь энэхүү тоног төхөөрөмжийн эвдрэлийн баталгаат хугацааны хүрээнд засвар үйлчилгээг хийнэ. Харин ашиглалтын буруутай үйл ажиллагаанаас шалтгаалсан эвдрэл гэмтэл бол бид хариуцах боломжгүй гэсэн мэдэгдэл хийсэн тул гүйцэтгэгч байгууллагын хамт сонсох ажиллагаа хийх саналтай.	Зөвлөмж өгөгдөж байгаа тул сонсох ажиллагаа шаардлагагүй мөн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс нь хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүнг хариуцдаг учир гэрээний дагуу шаардлага тавих үүрэгтэй. Иймд саналыг хүлээн авах боломжгүй байна.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 05 сарын 02 өдөр

№ 50/А2250433/ХӨА-2022/
16-21-ШТА-ГА

Мөрөн сум

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Улсын төсвийн 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Барилга захиалагчийн хяналтын төв” нь улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг бодитой хянаагүйгээс гадна санхүүжилтийн эрхийг нээж буй аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, мэргэжилтэн нар нь гүйцэтгэлийг хянаагүйгээс хийгдээгүй ажлын гүйцэтгэлд санхүүжилтийг олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.1.2.9 “улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төслийн гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлэх, гүйцэтгэлийн санхүүжилтийг хянан баталгаажуулах”, 2.1.3 “Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нээж нь төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн санхүүжилт, хэрэгжилт, гүйцэтгэл, хяналтын үйл ажиллагаа, үр дүнг хариуцаж ажиллана”, 2.3.2.4 “барилга байгууламж, өргөтгөл, их засварын ажлыг байнгын ашиглалтад оруулах улсын комиссын актаар холбогдох дүрмийн дагуу ашиглалтад хүлээн авсны үндсэн дээр эцсийн санхүүжилт хүсэх”, дэх заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ.” Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. Үүнд: 4.2.1.4-д “төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн”, 4.2.1.11 хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг бодитой хянаагүй “Захиалагчийн барилгын техникийн хяналтын нэгдсэн дүгнэлт” гаргасан Барилга захиалагчийн хяналтын төв” ОНӨААТҮГ-ын дарга Д.Батчулуун, хийгдээгүй ажлын гүйцэтгэлд санхүүжилт олгосон аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Оюунтуяа, мэргэжилтэн Л.Занданмядагсүрэн нарт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 11 дүгээр сарын 20-

ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг аймгийн Засаг дарга
Ш.Идэрбаясгаланд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

АХЛАХ АУДИТОР

Э.БАТ-ЭРДЭНЭ



¹ Хөвсгөл аймаг Мөрөн хот АЗДТГ-ын "А" корпус 3 давхар 303 тоот



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 05 сарын 02 өдөр

№ 53/A2250433/ХӨА-2022/
16-21-ШТА-ГА

Мөрөн сум

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Тариалан сумын Халуун усны барилгын ажлын зураг, төсөвт тусгагдсан гадна тохижилтын ажил болон комиссын хурлын тэмдэглэлээр өгсөн ажил хийгдээгүй байхад улсын комисс ажиллаж хүлээж авсан.
2. Хүүхэд залуучуудын цэцэрлэгт хүрээлэн, биеийн тамирын талбайн ажлын зураг, төсөвт заагдсан чийрэгжүүлэх төхөөрөмж 5 ширхэг дутуу, жижиг гэрэл 4 ширхэг суурилагдаагүй, том гэрэл, 4 ширхэг суурилагдаагүй байхад улсын комисс ажиллаж хүлээж авсан.
3. Мөрөн сумын 3 дугаар цэцэрлэгийн барилгын их засварын ажлын дээврийн ус цуглуулах ховилыг зураг, төсөвт тусгагдсаны дагуу хийгээгүй, салбар цэцэрлэгийн цонхыг солихдоо хуучин модон цонхны суурин дээр хийсэн зай, завсартай байхад улсын комисс ажиллаж хүлээж авсан.
4. Цэцэрлэгийн барилга худалдан авах /Хөвсгөл, Жаргалант сум/ төсөл, арга хэмжээнд ажлын хэсгийн тэмдэглэлээр өгсөн ажил дутуу байхад улсын комисс хүлээж авсан.
5. Ренчинлхүмбэ сумын 320 хүүхдийн сургуулийн барилга баригдаж дуусаагүй байхад улсын комисс ажиллаж хүлээж авсан.

Энэ нь Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1-т “Барилга байгууламж дараахь шаардлагыг хангасан байна: 14.1.1.зураг төслийн дагуу баригдсан байх;”, Засгийн газрын 2021 оны 2012 тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 8.2.2-т “Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтийг үндэслэн 8.1-д заасан хугацаанд багтаан дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана: энэ дүрмийн 5.1, 6.1-д заасан шаардлага хангаагүй, 8.1-д заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангагдаагүй тохиолдолд татгалзсан дүгнэлт.” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ” гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зураг, төсөвт заагдсан ажил нь бүрэн хийгдээгүй, баригдаж дуусаагүй барилга, байгууламжид ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан Улсын комиссын гишүүдэд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж биелэлтийг 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэх,

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг, аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 302 тоот, Утас: 7038-4043

2. Цаашид зураг, төсөвт заагдсан ажил нь бүрэн хийгдээгүй, баригдаж дуусаагүй барилга, байгууламжид ашиглалтад оруулах комисс томилон ажиллуулахгүй байхыг Хөвсгөл аймгийн Засаг дарга Ш.Идэрбаясгаланд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР

АХЛАХ АУДИТОР

 Э.БАТ-ЭРДЭНЭ



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 05 сарын 02 өдөр

№ 49/А2250433/ХӨА - 2022/
16-21-ШТА-ГА

Мөрөн сум

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Улсын төсвийн 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Шинэ хөдөө төсөл хөтөлбөрийн хүрээнд “Махны чиглэлийн Сэлэнгэ үүлдрийн тугалтай 80 үнээ, 4 бух” нийлүүлэхээр Баяншувуут ХХК-тай 223.2 сая төгрөгийн гэрээ байгуулан барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлсэн боловч аудитаар тооллого хийхэд 40.5 сая төгрөгийн 22 үнээ, 19.6 сая төгрөгийн 28 бяруу, 10.0 сая төгрөгийн 2 бух нийт 70.1 /Далан сая нэг зуун мянган/ төгрөгийн 52 мал дутагдаж төрд хохирол учирсан зөрчил илэрлээ. Орон нутгийн өмчийн газрын даргын 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн “Хөрөнгө бүртгэх тухай” А/103 дугаар тушаалаар төслийн хүрээнд бий болсон малыг ОНӨГ-ын бараа материалын бүртгэлд бүртгэсэн бөгөөд цаашид малын эрүүл мэнд, хариулга маллагаа, иргэдэд түрээслэх ажлыг зохион байгуулахыг ХХААЖД-ийн газрын даргад даалгасан байна. Гэвч бодит байдал дээр малыг байршуулах газар, хашаа, худаг ус, өвс, маллах малчны асуудал бүрэн шийдэгдээгүй, малыг хэрхэн онд мэнд оруулах талаар зохион байгуулалттай ажил хийгдээгүйгээс дээрх хорогдол гарч төсөл, арга хэмжээний үр дүн буурахад нөлөөлсөн байна. Мөн барааны техникийн тодорхойлолтод “Сэлэнгэ” үүлдрийн үнээ нь 3-4 настай байх гэж заасан байхад нийлүүлэгдсэн үхэр дотор хөгшин хээлтэгч үнээ нэлээдгүй байсан нь барааг техникийн тодорхойлолтод заасны дагуу хүлээж аваагүйг харуулж байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 4/ “үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ. Санаатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрх баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад шилжүүлнэ.” Төрийн албаны тухай хуулийн 37.1. “Төрийн албан хаагч дараах нийтлэг үүрэг хүлээнэ:” 37.1.18. “хууль тогтоомжид заасан бусад үүрэг”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 12.2. “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ” 12.2.3. “эд хөрөнгө дутагдсан, эд хөрөнгийг хууль бусаар зарцуулсан байж болзошгүй гэж үзсэн үед;” Орон нутгийн өмчийн газрын даргын 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн “Хөрөнгө бүртгэх тухай” А/103 дугаар тушаалаар өгсөн үүрэг даалгавар” дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ.” Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. Үүнд: 4.2.1.4-д “төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн”, 4.2.1.11 хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан

гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал”заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн хөрөнгийн ашиглалт, арчлалт, хадгалалт, зохион байгуулалтад хариуцлага алдсан Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Должинсоргодог, мэргэжилтэн Ц.Бэхбаяр, Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга Я.Эрхэмбаяр нарт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 11 сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг аймгийн Засаг дарга Ш.Идэрбаясгаланд даалгав.

	АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:	
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР		А.ЭРДЭНЭБААТАР
АХЛАХ АУДИТОР		З.БАТ-ЭРДЭНЭ

¹Хөвсгөл аймаг Мөрөн хот АЗДТГ-ын “А” корпус 3 давхар 303 тоот



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 05 сарын 02 өдөр

№ 47/ХӨА-2022/16-21-
-ШТА-ГА

Мөрөн сум

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


1. Спорт заал худалдан авах /Хөвсгөл, Жаргалант сум/ төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр 0.4 сая төгрөгийн татварын өртэй “Денсфорист” ХХК шалгаруулсан.
2. Тариалан сумын бэлчээрийн худаг, Тосонцэнгэл сумын бэлчээрийн худаг төсөл, арга хэмжээнүүдийн гүйцэтгэгчээр гүний худгийн цооног өрөмдөх зөвшөөрөлгүй “Хөвсгөл геологи” ХХК-г шалгаруулсан
3. “Шинэ хөдөө” төсөл /Хөвсгөл/ багц-6: Инженерийн хийцтэй гүний худаг төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр гүний худгийн цооног өрөмдөх зөвшөөрөлгүй “Хөвсгөл геологи” ХХК-г шалгаруулсан.
4. Багийн төвийн барилга барих /Тариалан сум, Таван толгой баг/, Цэцэрлэг сумын 7 дугаар багт Ундны ус зөөвөрлөх авто машин худалдан, Багийн засаг дарга, багийн эмчийг унаажуулах /Хөвсгөл/, Баянзүрх сумын нийтийн халуун усны барилга, Алаг-Эрдэнэ сумын нийтийн халуун усны барилга гэсэн 5 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр боловсон хүчин, техникийн чадавх, хэрэгжүүлж буй ажлын байдлыг бүрэн үнэлэлгүй “Төрөлх мөрөн” ХХК-г шалгаруулсан.
5. Цагаан-Үүр сумын Ахмадын төвийн барилга, Чандмань-Өндөр сумын Ахмадын төвийн барилга гэсэн 2 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр боловсон хүчин, техникийн чадавх, хэрэгжүүлж буй ажлын байдлыг бүрэн үнэлэлгүй “Тэмээн” ХХК-г шалгаруулсан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1-т “Тендер нээсний дараа тендер тус бүр нь дараахь шаардлагыг хангасан эсэхийг хянан үзнэ: 27.1.1.энэ хуулийн 14-16 дугаар зүйлд заасныг үндэслэн захиалагчийн тогтоосон чадавхийн шаардлага,” 27.4.-т “Энэ хуулийн 27.3-т зааснаас бусад тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзэж захиалагч уг тендерээс татгалзана.” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ” гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тендерийн баримт бичиг, хуульд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаагүй хуулийн этгээдийг сонгон шалгаруулсан дээрх худалдан авах ажиллагаануудын үнэлгээний хорооны дарга нар болох аймгийн Засаг даргын орлогч М.Хуягбаатар, Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга Б.Мөнгөн-Эрдэнэ, Худалдан авах ажиллагааны албаны дарга Б.Болд, Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн Н.Шинэбаяр нарт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж биелэлтийг 2022

оны 07 дугаар сарын 05-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Ариунбатад даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР
АУДИТОР  З.ДАВААДОРЖ

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг, аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 302 тоот, Утас: 7038-4043



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 05 сарын 02 өдөр

№ 48/А.2250433/ХӨА - 2022/
16-21-ШТА-ГА

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Улсын төсвийн 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 25 ширхэг мотоцикл нийлүүлэх тендерт Төрөлх Мөрөн ХХК-ийг сонгон шалгаруулсан бөгөөд зах зээлийн үнээс өндөр үнээр нийлүүлсэн, мотоциклийг ашиглагч байгууллагад биетээр хүлээлгэж өгөөгүй байхад “Хөрөнгө бүртгэх” тухай тушаал гарган ашиглагч байгууллагын санхүүгийн тайланд тусгуулсан зөрчил илэрлээ.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл Нягтлан бодох бүртгэлийн зарчим 5.1.4 “үнэн зөв байх”, 13.6 “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.” 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” дахь заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 2 дахь заалтыг тус тус зөрчсөн, “оршин байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. Үүнд: 4.2.1.4-д “төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн” , 4.2.1.11 хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хөрөнгөөр зах зээлийн үнээс өндөр дүнтэй хөрөнгө бэлтгэсэн болон хөрөнгө ашиглагч байгууллагад биетээр байхгүй байхад санхүүгийн тайланд тусгуулсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар-т ирүүлэх;

¹ Хөвсгөл аймаг Мөрөн хот АЗДТГ-ын “А” корпус 3 давхар 303 тоот

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Должинсоргодог, мэргэжилтэн Ц.Бэхбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР

А.ЭРДЭНЗБААТАР
Э.БАТ-ЭРДЭНЭ



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2022 оны 05 сарын 02 өдөр

№ 52/А 2250433/ХӨА - 2022/16-
-21- ШТА-ГА

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Захиалагчийн хяналтыг Хөвсгөл аймгийн Барилга захиалагчийн хяналтын төвөөс гүйцэтгэж байхад захиалагчийн хяналт гүйцэтгээгүй Орон нутгийн өмчийн газрын гэрээт албан хаагчийн цалинд 7,000,000 төгрөг, бичиг хэргийн зардалд 8,900,000 төгрөг, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт 28,700,000 төгрөг нийт 44,600,000/дөчин дөрвөн сая зургаан зуун мянга/ төгрөгийг тус тус шилжүүлж барилга байгууламжийн захиалагчийн хяналтын зардлаас санхүүжүүлэх зардлын нэр төрөлд хамаарахгүй зардалд зарцуулсан байна

Энэ нь Барилгын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.9-д “барилгын ажлын захиалагчийн дүрмийг батлах;” Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 2.7-д “Захиалагчийн санхүүжилтийн эх үүсвэр нь барилга байгууламжийн төсөвт өртөлт тусгагдсан байх бөгөөд зардлыг зориулалтын дагуу ашиглана.”, Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 85 дугаар тушаалаар батлагдсан “Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын зардлаас санхүүжүүлэх зардлын нэр төрөл”-д нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дугаар зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль, тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал.” гэсэн заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Захиалагчийн хяналтын зардлыг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2022 оны 11 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹-т ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй, барилга байгууламжийн захиалагчийн хяналтын зардлаас санхүүжүүлэх зардлын нэр төрөл, захиалагчийн үйл ажиллагаанд хамаарах зардалд зориулалтын дагуу зарцуулж, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Б.Должинсорогдог, Худалдан авах ажиллагааны албаны дарга Б.Болд нарт даалгав.

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг, аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 302 тоот, Утас: 7038-4043

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР
АХЛАХ АУДИТОР  Э.БАТ-ЭРДЭНЭ

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг, аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 302 тоот, Утас: 7038-4043



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 05 сарын 02 өдөр

№ 51/А.2250433/ХӨА-2022/
16-21-ШТА-ГА

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Улсын төсвийн 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв” ОНӨААТҮГ нь Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 2.2, 2.8-д заасны дагуу аймгийн Засаг даргатай 271.9 сая төгрөгийн гэрээ байгуулж ажилласан бөгөөд гэрээнд заасан хугацаанд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхдээ гүйцэтгэлийг бодитой хянаагүй, ажил нь бүрэн дуусаагүй барилгад “Захиалагчийн техникийн хяналтын дүгнэлт” гаргасан, барилга угсралтын явцад хяналт хийх давтамж бага, хяналтаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг эргэж шалгаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 2.10 “Захиалагч барилгын тухай хуулийн 16.3-т заасан барилгын ажлын талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төслийн дагуу барилгын ажлыг гүйцэтгэнэ”. Аймгийн засаг даргатай байгуулсан “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих барилга, байгууламжийн ажлын гүйцэтгэлд барилга захиалагчийн хяналт хэрэгжүүлэх гэрээний 5.1 Зөвлөх нь үйлчилгээг мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд үнэнч шударгаар үзүүлнэ. Энэхүү гэрээний дагуу зөвлөхийг ажиллуулж буй аливаа ажилтан шаардлага хангаагүй гэж захиалагч үзсэн бол зөвлөх уг ажилтныг нэн даруй солино”. Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 4.7 “Захиалагч, гүйцэтгэгч талууд илэрсэн зөрчил дутагдлыг 14 хоногт багтаан арилгаж, комиссын хуралдаанаас даалгасан үүрэг даалгаврын биелэлтийг хангаж, шаардлагатай баримт бичгийг бүрдүүлнэ”, дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. Үүнд:...4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал”-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхдээ гүйцэтгэлийг бодитой хянаагүй, ажил нь бүрэн дуусаагүй барилгад “Захиалагчийн техникийн хяналтын дүгнэлт” гаргасан зөрчлийг арилгах, үүрэг даалгавар өгсөн боловч хэрэгжээгүй төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд хяналт тавьж ажлыг гүйцэтгүүлэн биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар-т ирүүлэх;

¹ Хөвсгөл аймаг Мөрөн хот АЗДТГ-ын “А” корпус 3 давхар 303 тоот

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг “Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв” ОНӨААТҮГ-ын дарга Д.Батчулуунд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР
Э.БАТ-ЭРДЭНЭ

Хавсралт-1

Захиалагчийн техникийн хяналтын дүгнэлт гарч, улсын комисс хүлээн авсан ч зурагт
заагдсан ажил нь бүрэн хийгдээгүй барилгын жагсаалт

№	Барилга байгууламжийн нэр	Гүйцэтгэгч компанийн нэр
1	Тариалан сумын халуун усны барилга	Голден прогресс ХХК
2	Хүүхэд залуучуудын цэцэрлэгт хүрээлэн	Хөвсгөл Мон Трэйвел ХХК
3	Мөрөн сумын 3 дугаар цэцэрлэгийн барилгын их засвар	Эндус-Эрхэт ХХК
4	Цагаан-Үүр сумын Цэцэрлэгийн барилгын их засвар	Бумбах ХХК
5	Цэцэрлэгийн барилга худалдан авах /Хөвсгөл, Жаргалант сум/	Дээд хонх ХХК
6	Ренчинлхүмбэ сумын 320 хүүхдийн сургуулийн барилга	Хөвсгөл суварга ХХК



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2022 оны 05 сарын 02 өдөр

№ 11/A220433/ХӨА-2022/16-
-21-ШТА-ГА

Мөрөн сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Улсын төсвийн 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжихээр төлөвлөгдсөн ч гэрээнд заасан хугацаанд ажлаа хийгээгүй, гэрээний хугацаа дууссан байхад гэрээг сунгаагүй, алданги тооцож ажиллаагүй байна. Үүнд:

❖ Хүслийн хад аялал жуулчлалын төвийн зураг, төсвийн ажлыг гүйцэтгэгч Алтай газрын хүч ХХК 3.5 сая төгрөг,

❖ Тариалан сумын Багийн мэдээллийн төвийн барилгын ажил болон Цэцэрлэг сумын 7 дугаар багийн усны машин нийлүүлэх ажлыг гүйцэтгэгч Төрөлх Мөрөн ХХК 2.0 сая төгрөг

Энэ нь ХӨАОНӨГ/202104165, ЗГХЭГ/202102031/03/01, ЗГХЭГ/202102031/03/01/багц6 дугаартай гэрээний тусгай нөхцөлийн ГЕН 46.0 заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 -т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.” Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” Үүнд: 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Гэрээнд заасан хугацаанд ажил, үүргээ гүйцэтгээгүй, гэрээгээ сунгаагүй аж ахуйн нэгжид алданги болох нийт 5,500,000 /Таван сая таван зуун мянган/ төгрөгийн алдангийг төлүүлж Хөвсгөл аймгийн Төрийн сан дахь 100170000955 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Оюунтуяа, Л.Занданмядагсүрэн нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЗБААТАР

АХЛАХ АУДИТОР

Э.БАТ-ЭРДЭНЭ

Гүйцэтгэгч сонгон шалгаруулж гэрээ байгуулсан хугацаа

Хавсралт-1

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Тендер хүлээж авсан эцсийн хугацаа	Эрх олгосон огноо	Гэрээ байгуулах эрх олгоход зарцуулсан хоног	Эрх олгосон огноо	Байгуулсан огноо	Гэрээ байгуулахад зарцуулсан хоног	Нийт зарцуулсан хоног
1	Спорт заал худалдан авах /Хөвсгөл, Жаргалант сум/	2021.07.22	2021.08.13	22	2021.08.13	2021.08.20	7	29
2	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр-багц-1: Ёслол хүндэтгэлийн өргөөний тохижилт, тоног төхөөрөмж худалдан авах /Улаан-Уул сум/	2021.07.26	2021.08.05	11	2021.08.05	2021.08.17	12	23
3	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр-багц-2: Өл, Тоомын давааны гүүрүүдийг засварлах, үерийн далан барих /Улаан-Уул сум/	2021.07.26	2021.08.05	11	2021.08.05	2021.08.17	12	23
4	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр-багц-4: Багийн төвийн барилга барих /Тариалан сум, Таван толгой баг/	2021.09.06	2021.09.17	11	2021.09.17	2021.09.30	13	24
5	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр-багц-5: Багийн Засаг дарга нарыг тоног төхөөрөмжөөр хангах	2021.12.16	2021.12.20	4	2021.12.20	2021.12.28	8	12
6	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр-багц-6: Ундны ус зөөвөрлөх авто машин худалдан авах /Цэцэрлэг сум, 7 дугаар баг/	2021.09.06	2021.09.17	11	2021.09.17	2021.09.29	2	13
7	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр-багц-7: Оёдлын цехийн тоног төхөөрөмж худалдан авах /Хөвсгөл/	2021.09.06	2021.09.17	11	2021.09.17	2021.10.04	18	29
8	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр-багц-8: Багийн засаг дарга, багийн эмчийг унаажуулах /Хөвсгөл/	2021.09.06	2021.09.17	11	2021.09.17	2021.09.29	12	23
9	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр-багц-9: Үлийн цагаан оготно устгалын багаж худалдан авах /Цэцэрлэг, Цагаан-Уул, Шинэ-Идэр сум/	2021.07.26	2021.08.05	11	2021.08.05	2021.08.17	12	23
10	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр-багц-10: Таван ханатай гэр худалдан авах /Хөвсгөл/	2021.11.15	2021.11.19	4	2021.11.19	2021.11.29	10	14
11	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр-багц-11: Малын арьс, шир боловсруулах тоног төхөөрөмж худалдан авах /Баянзүрх, Эрдэнэбулган сум/	2021.07.26	2021.08.05	11	2021.08.05	2021.08.17	12	23
12	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр-багц-12: Ногоон тэжээлийн үр худалдан авах /Хөвсгөл, Галт, Жаргалант, Их-Уул, Цэцэрлэг, Цагаан-Уул, Улаан-Уул/	2021.09.06	2021.09.17	11	2021.09.17	2021.10.04	17	28
13	"Соёмбо" цэцэрлэгт хүрээлэн /Хөвсгөл, Мөрөн сум/	2021.08.25	2021.09.01	5	2021.09.01	2021.09.15	14	19
14	Дархадын хотгорын цөлжилтийг бууруулах, Цойцон нуурыг нөхөн сэргээх /Хөвсгөл, Ренчинлхүмбэ сум/	2021.06.07	2021.06.21	14	2021.06.21	2021.07.02	11	25
15	"Хүслийн хад" аялал жуулчлалын төвийн зураг төсөв /Хөвсгөл, Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгон/	2021.05.17	2021.06.04	18	2021.06.04	2021.06.14	10	28
16	Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын их засвар /Улсын хэмжээнд/-Хөвсгөл аймгийн нисэх онгоцны буудлыг жуулчдад зориулж тохижуулах ажил	2021.08.17	2021.08.19	2	2021.08.19	2021.08.20	1	3
17	Ахмадын өргөөний барилга /Хөвсгөл, Шинэ-Идэр сум/	2021.06.25	2021.06.29	4	2021.06.29	2021.07.09	10	14
18	Ахмадын төвийн барилга /Хөвсгөл, Баянзүрх, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сум/	2021.09.23	2021.09.27	4	2021.09.27	2021.10.11	14	18
		2021.08.02	2021.08.18	16	2021.08.18	2021.08.27	11	27
		2021.08.02	2021.08.18	16	2021.08.18	2021.08.27	11	27
	Ундны усны худаг /Хөвсгөл, Мөрөн сум/	2021.05.19	2021.05.25	6	2021.05.25	2021.06.10	15	21
19	Халуун усны барилга /Хөвсгөл, Тариалан сум/	2021.06.22	2021.07.07	15	2021.07.07	2021.07.22	15	30

20	Нийтийн халуун усны барилга /Хөвсгөл, Баянзүрх, Алаг-Эрдэнэ сум/	2021.09.03	2021.09.15	12	2021.09.15	2021.09.30	15	27
						2021.09.29	14	14
21	Гэр хорооллын хөрсний бохирдлыг багасгах эко ариун цэврийн байгууламж /Хөвсгөл, Мөрөн сум/	2021.06.10	2021.06.25	15	2021.06.25	2021.07.09	14	29
22	Цэцэрлэгийн барилга худалдан авах /Хөвсгөл, Жаргалант сум/	2021.05.31	2021.06.21	21	2021.06.21	2021.06.29	8	29
23	Боловсрол, соёлыг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл/	2021.04.19	2021.05.06	17	2021.05.06	2021.05.17	13	30
24	Багшийн хөгжлийн төвийн тоног төхөөрөмж /Хөвсгөл/	2021.03.30	2021.04.09	10	2021.04.09	2021.04.28	19	29
25	Бэлчээрийн худаг /Хөвсгөл, Тариалан, Тосонцэнгэл, Цэцэрлэг сум/	2021.06.22	2021.06.29	7	2021.06.29	2021.07.09	10	17
		2021.06.22	2021.06.29	7	2021.06.29	2021.07.09	10	17
		2021.07.27	2021.08.03	6	2021.08.03	2021.08.19	16	22
		2021.07.27	2021.08.03	6	2021.08.03	2021.08.19	16	22
		2021.06.24	2021.06.30	6	2021.06.30	2021.07.09	19	25
		2021.06.24	2021.06.30	6	2021.06.30	2021.07.09	19	25
		2021.07.27	2021.08.03	6	2021.08.03	2021.08.26	23	29
		2021.06.24	2021.06.30	6	2021.06.30	2021.07.21	22	28
26	"Шинэ хөдөө" төсөл /Хөвсгөл/							
27	Төмс, хүнсний ногоо тариалдаг хөдөөгийн багуудыг эрчим хүчинд холбох /Хөвсгөл, Бүрэнтогтох сум, Их-Уул, Эрчим баг/	2021.05.17	2021.05.31	14	2021.05.31	2021.06.15	16	30
28	Хавдрын эрт илрүүлгийн төвийн барилга худалдан авах /Хөвсгөл, Мөрөн сум/	2021.04.30	2021.05.14	15	2021.05.14	2021.05.25	9	24
		2021.04.19	2021.05.05	16	2021.05.05	2021.05.14	9	25
29	Сумдын эрүүл мэндийн төвийн лаборатори, тоног төхөөрөмж /Хөвсгөл/	2021.07.19	2021.08.03	15	2021.08.03	2021.08.20	17	32
		2021.04.19	2021.05.05	16	2021.05.05	2021.05.17	12	28
						2021.05.11	15	22
30	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээнд мобайл технологийг нэвтрүүлэх /Хөвсгөл, Алаг-Эрдэнэ, Арбулаг, Бүрэнтогтох, Тариалан, Түнэл, Цагаан-Үүр, Цэцэрлэг, Чандмань-Өндөр, Шинэ-Идэр, Эрдэнэбулган сум/	2021.04.19	2021.04.26	7	2021.04.26	2021.05.11	15	15
31	Дотуур байрны их засвар /дулаалга, сантехникийн/ Хөвсгөл, Арбулаг сум/	2021.04.14	2021.04.15	1	2021.04.15	2021.04.26	11	12
32	Цэцэрлэгийн барилгын их засвар /Хөвсгөл, Цагаан-Үүр сум/	2021.04.12	2021.04.20	8	2021.04.20	2021.04.28	8	16
33	Сургуулийн дотуур байрны гүний худгийн шугам сүлжээний засвар /Хөвсгөл, Чандмань-Өндөр сум/	2021.06.02	2021.06.03	1	2021.06.03	2021.06.16	13	14
34	Сургуулийн их засвар /Хөвсгөл, Ханх сум/	2021.04.15	2021.04.21	6	2021.04.21	2021.05.04	13	19
35	Цэцэрлэгийн барилгын их засвар /Хөвсгөл, Ханх сум/	2021.04.15	2021.04.22	7	2021.04.22	2021.05.04	12	19
36	Цэцэрлэгийн сантехникийн засвар /Хөвсгөл, Алаг-Эрдэнэ сум/	2021.06.02	2021.06.03	1	2021.06.03	2021.06.29	16	17
37	XIII.3.1.2.11 -Гуравдугаар цэцэрлэгийн барилгын их засвар /Хөвсгөл, Мөрөн сум/	2021.08.04	2021.08.09	5	2021.08.09	2021.08.23	14	19
38	Дотуур байрны их засвар /дээвэр, дулаалга, хаалга, шал/ Хөвсгөл, Цагаан-Уул сум	2021.05.20	2021.05.25	5	2021.05.25	2021.06.07	12	17
39	Жаргалант, Галтын авто замын засвар /Хөвсгөл, Жаргалант, Галт сум/	2021.10.04	2021.10.08	4	2021.10.08	2021.10.20	12	16
	Нийт			475			669	1144

Төсөл, арга хэмжээг гэрээнд заасан хугацаанд хэрэгжүүлээгүй, гэрээ сунгаагүй алданги тооцоогүй байгууллагуудын жагсаалт

Хавсралт-2

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Гэрээний дүн /сая.төг/	Гүйцэтгэгч компани	Эхлэх дуусах огноо	Хүлээж авсан огноо	Алданги хоног	Алданги дүн
1	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл, Жаргалант, Галт, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Их-Уул, Рашаант сум/ IV.1.29/ багц-6	40.0	Төрөлх Мөрөн ХХК	2021.09.30 2021.11.30	Гэрээ сунгаагүй	50	2.0
2	Хүслийн хад аялал жуулчлалын төвийн зураг, төсөв /Хөвсгөл, Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгон/	46.2	Алтай газрын хүч ХХК	2021.11.05 2021.12.25	Гэрээ сунгаагүй	115	3.5
НИЙТ ДҮН							5.5

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан жагсаалт

Хавсралт-3

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Сайдын багц	Ажил эхлэх, дуусах хугацаа	Гүйцэтгэгч компани	Төсөвт өртөг /сая.төг/	Барьцаа дансанд байршуулсан дүн /сая.төг/
1	Цэцэрлэгийн сантехникийн засвар /Хөвсгөл, Алаг-Эрдэнэ сум/	БШУС	2021.06.29 2021.07.19	Сант өндөрт ХХК	5.0	5.0
2	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл, Жаргалант, Галт, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Их-Уул, Рашаант сум/ IV.1.29/ багц-3 /Өл тоом/	ЗГХЭГД	2021.08.20 2021.11.30	Эрдэнийн харгуй ХХК	60.0	30.0
3	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл, Жаргалант, Галт, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Их-Уул, Рашаант сум/ IV.1.29/ багц-4	ЗГХЭГД		Төрөлх мөрөн ХХК	50.0	50.0
4	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл, Жаргалант, Галт, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Их-Уул, Рашаант сум/ IV.1.29/ багц-5	ЗГХЭГД	2021.12.28 2021.12.30	Дижитал сервис ХХК	69.9	69.6
5	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл, Жаргалант, Галт, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Их-Уул, Рашаант сум/ IV.1.29/ багц-6	ЗГХЭГД		Төрөлх мөрөн ХХК	40.0	40.0
6	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл, Жаргалант, Галт, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Их-Уул, Рашаант сум/ IV.1.29/ багц-10	ЗГХЭГД	2021.11.19 2022.12.10	Соёмбот ажнай	45.0	43.9
7	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл, Жаргалант, Галт, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Их-Уул, Рашаант сум/ IV.1.29/ багц-12	ЗГХЭГД	2021.10.04 2022.03.22	Торгон зүлэг ХХК	56.0	56.0
8	Засаг даргын Тамгын газрын барилга /Хөвсгөл, Цагаан үүр сум/	ЗГХЭГД	2020.08.01 2021.08.30	Тэмээн ХХК	1,197.8	134.2
9	Хүслийн хад аялал жуулчлалын төвийн зураг, төсөв /Хөвсгөл, Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгон/	БОАЖС	2021.07.01 2021.08.25	Алтай газрын хүч ХХК	46.2	46.2
10	"Шинэ хөдөө" төсөл /Хөвсгөл-Хөвсгөл геологи ХХК	ХХААХҮС	2021.07.01 2021.10.01	Хөвсгөл Геологи ХХК	20.0	20.0
11	"Шинэ хөдөө" төсөл /Хөвсгөл/	ХХААХҮС	2021.08.30 2021.11.30	Шидэт Гал ХХК	43.9	43.9
НИЙТ ДҮН					1,663.8	538.8